

Тайлан № 106724-МН

МОНГОЛ УЛС

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих
төсөл (P118109)

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих
төсөл - Нэмэлт санхүүжилт (P145349)

ХОЁРДАХЬ ТАЙЛАН БА ЗӨВЛӨМЖ

2016 оны 7 дугаар сарын 6-ны өдөр



ip

The
Inspection
Panel

THE WORLD BANK

IBRD • IDA | WORLD BANK GROUP

Хяналтын хороо

Хяналтын хороонд ирүүлсэн хүсэлтэд гаргасан хоёрдахь тайлан ба зөвлөмж

Монгол Улс: Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109) Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл – Нэмэлт санхүүжилт (P145349)

А. Удиртгал

1. 2015 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Хяналтын хороо (цаашид “Хороо” гэнэ) Монгол Улс, ОХУ-ын орон нутгийн байгууллага болон иргэдийн төлөөллөөс хянан шалгалт хийлгэх хүсэлт (цаашид “Хүсэлт” гэнэ) хүлээн авсан. Уг хүсэлтэд **Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109)** болон **Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл – Нэмэлт санхүүжилт (P145349)** (цаашид эдгээр 2 төслийг “УУДБХОДТ” эсвэл “Төсөл” гэнэ) төслийн дор санхүүжиж буй үйл ажиллагааны улмаас учирч болзошгүй хор хохирлын талаарх асуудлуудыг хөнджээ. Хүсэлт гаргагчид хорооноос тэдний хувийн нууцыг хадгалахыг хүссэн бөгөөд “Хил хязгааргүй гол мөрөн” байгууллагаас тус хүсэлтэд хамаарах асуудлаар харилцах 2 хүнийг Монгол, Орос Улсад төлөөлүүлэн томилсон байна.

2. УУДБХОДТ нь Олон улсын хөгжлийн агентлагаас санхүүжигдэх техникийн туслалцааны төсөл бөгөөд Зөвлөл 2011 оны 5 дугаар сарын 10-нд 25 сая ам.долларын төсөв батласан. 2014 онд 4.2 сая ам.долларын нэмэлт санхүүжилт батлагдсан. Төслийн хөгжлийн зорилтууд нь “санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхийг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг бэлтгэж, хэрэгжүүлэх дотоодын чадавхийг нэмэгдүүлэхэд орших” юм.¹

3. Хүсэлтэд УУДБХОДТ төсөл нь Шүрэнгийн усан цахилгаан станц төсөл (Шүрэнгийн УЦС), Орхон-Говь ус дамжуулах төсөл (ОГТ) зэрэг хоёр дэд төслийн үнэлгээний судалгаа хийхийг дэмжиж байгаа нь Монгол Улсын нутагт байрлах Сэлэнгэ мөрөн, Дэлхийн өвийн жагсаалтанд бүртгэгдсэн ОХУ-ын нутагт байрлах Байгаль нуурт байгаль орчин, нийгмийн эргэж нөхөгдөшгүй нөлөө үзүүлж болзошгүй гэж дурджээ. Хүсэлт гаргагчид эдгээр дэд төслийн сонгон шалгаруулалт хийсэн байдалд эргэлзэж буйгаа илэрхийлж, хил дамнасан болон хуримтлагдах нөлөөлөлтэй холбоотой санаа зовоосон асуудлуудыг хөндсөний зэрэгцээ зөвлөлдөх уулзалт хийгээгүй, мөн мэдээллийг олон нийтэд ил болгоогүй хэмээн гомдол гаргажээ.

4. Хороо 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хүсэлтийг бүртгэн авч, Банкны удирдлага болон Гүйцэтгэх захирлын зөвлөлд (цаашид “Зөвлөл” гэх) мэдэгдсэн. Албан томилолтын үеэр хороо ОХУ-ын Байгаль нуурын эрэг хавиар оршин суудаг, мөн Монгол Улсын Эрдэнэт хот орчимд амьдардаг нутгийн иргэдээс дээрх хүсэлтэд нэмж оруулах хоёр

¹ Төслийн үнэлгээний баримт бичиг. Монгол Улсын Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл. Дэлхийн Банк. 2011 оны 4 дүгээр сарын 7. Хуудас 4.

баримтыг хүлээн авсан.

5. Банкны удирдлагаас 2015 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр ирүүлсэн хариундаа Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ) болон Ажлын даалгавар монгол хэл дээр орчуулагдсан тул УУДБХОДТ нь Банкны бодлогын зөвлөлдөх, мэдээлэл түгээх шаардлагыг хангасан болохыг мэдэгдсэн. Удирдлага Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрууд хоёр дэд төслийн асуудлаар хоёр талын хамтарсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан талаар мэдэгдэж, *“санал болгож буй дэд төслүүдийн талаар оролцогчдын зүгээс тавьсан асуулт, санаа зовоосон үндэслэл бүхий асуудлуудыг нарийвчлан судалж, үнэлгээний иж бүрэн судалгаа хэрэгжүүлэх тал дээр Хүлээн авагчийг дэмжиж ажиллахыг зорьж байна”* хэмээн дурджээ.² Мөн зөвлөлдөх, олон нийтэд мэдээлэл түгээх, үнэлгээний судалгаа хийх ажлыг *“Банкны бодлого, журамд нийцүүлэн зохих ёсоор явуулах явдлыг”* хангах болно гэдгийг нэмж дурджээ.³

6. Монгол, Орос Улсад хийсэн албан томилолтын дараа 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Хорооноос Зөвлөлд өгсөн тайлан, зөвлөмжид уг хүсэлтийн техникийн нийцтэй байдлыг баталгаажуулсан байна.⁴ Хороо нь үйл ажиллагааныхаа журмыг баримтлан хүсэлт, төсөл хоёрт дурдагдсан боломжит хор хохирлын хооронд үндэслэл бүхий уялдаа холбоо байгааг тогтоожээ. Хүсэлтийн хариуд удирдлагын зүгээс өгсөн үүрэг амлалт нь хүсэлт гаргагчдын гаргаж тавьсан асуудлыг шийдвэрлэх, бүх оролцогч талыг хамруулан үр дүнтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, тэр дундаа ОХУ-д зохион байгуулах явдлыг хангахтай холбогдуулан шаардлагатай залруулах арга хэмжээ авах өргөн боломжоор хангасан гэж Хорооноос үзэж байна. Ийнхүү хийсэн ажиглалтдаа тулгуурлан Хороо нь Банкны үйл ажиллагаанд хяналт тавих шаардлагатай эсэх талаар зөвлөмж гаргахад нэг жилээр хойшлуулсан болно. Зөвлөл 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Хорооны зөвлөмжийг баталсан.

7. 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Сангийн сайд техникийн талын ажлыг гүйцэтгэж дуусгах, мэдээллийг олон нийтэд түгээх, зөвлөлдөх уулзалт зохион байгуулахад зориулж төслийн одоогийн хаалтын огноо 2016 оны 9 дүгээр сар байсныг 24 сараар сунгах хүсэлт гаргасан. Банк одоогоор уг хугацаа сунгах хүсэлтийг авч үзэж байгаа болно.

Б. Хорооноос нийцтэй байдлын анхны тайлан гаргаснаас хойших төслийн өрнөл

8. **Удирдлагын шинэчлэгдсэн мэдээллийн баримт бичиг.** Гарсан ахицын талаар Хороонд мэдээлэх зорилгоор Удирдлага Шинэчлэгдсэн мэдээний тэмдэглэлийг 2016 оны 5 дугаар сарын 17-нд Хороонд ирүүлсэн.⁵ Уг мэдээлэлд Хорооноос нийцтэй

² Хянан шалгалт хийлгэх хүсэлтэд өгсөн удирдлагын хариу. Хорооноос Монгол Улсын “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл – Нэмэлт санхүүжилт” төсөлд хийсэн хянан шалгалт. Дэлхийн Банк. 2015 оны 4 дүгээр сарын 21. Хуудас 29-30.

³ Мөн тэнд Хуудас 30.

⁴ Монгол Улс: “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” ба “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл - Нэмэлт санхүүжилт” төслийг хянан шалгуулах хүсэлтийн хариуд гаргасан тайлан, зөвлөмжийг Хавсралт I-ээс үзнэ үү. Хяналтын хороо. 2015 оны 7 дугаар сарын 2.

⁵ Удирдлагаас Хороонд ирүүлсэн шинэчлэгдсэн мэдээний тэмдэглэлийг II хавсралтаас үзнэ үү. 2016 оны 5 дугаар сарын 17.

байдлын анхны тайланг гаргаснаас хойш “зөвлөлдөх, ажлын даалгаврыг дахин хянах, шинэчлэх тал дээр ихээхэн ахиц гарсан” гэж Удирдлага мэдэгдсэн байна.⁶

9. Зөвлөлдөх уулзалтууд: 2015, 2016 онд төсөл хэрэгжүүлэгч агентлагууд Монгол Улсад найман удаа зөвлөлдөх уулзалт зохион байгуулснаас тав нь Шүрэнгийн УЦС, гурав нь ОГ төслийн талаарх ойлголт, ажлын даалгаврыг хэлэлцэхэд чиглэгдсэн байна. Эдгээр арга хэмжээнд оролцсон оролцогчдын дунд голдуу төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй нутаг дэвсгэрт амьдардаг малчид болон бусад оролцогчид байв. Төслийн удирдлагын нэгж (ТУН) эдгээр зөвлөлдөх уулзалт тус бүрт зориулж хариултын матриц хүснэгт боловсруулж, санал болгосон зөвлөмжүүдийг харгалзан үзсний үндсэн дээр ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулжээ.

10. Оросын оролцогч талууд ОХУ-д гурван удаа зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан гэж Удирдлага мэдэгдсэн. 2015 оны 11 дүгээр сард бүс нутгийн иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ-ууд) хамтран Сибирийн гол мөрнүүд сэдэвт бүс нутгийн хурал зохион байгуулсан. Банкны удирдлага тус хуралд оролцож, байгаль орчны хамгааллын бодлогуудаа танилцуулж, зөвлөмжүүдийг хүлээн авсан бөгөөд БОННБҮ, ажлын даалгаврын эцсийн хувилбарыг боловсруулах явцад тусгуулах зорилгоор ТУН-д танилцуулжээ. 2016 оны 2 дугаар сард Буриад улсын Кабански дүүрэгт зохион байгуулсан оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтад Дэлхийн Банкны төлөөлөл оролцоогүй ч санал хүсэлтүүдийг хүлээн авсан. 2016 оны 4 дүгээр сард ОХУ-ын Байгалийн нөөц, байгаль орчны яамнаас (БНБОЯ) эрхлэн байгаль орчны чиглэлийн судлаачид, иргэний нийгмийн байгууллага, Буриад улсын төрийн албан тушаалтнуудыг хамруулсан техникийн хэлэлцүүлэг Москва хотод зохион байгуулсан. Уг уулзалтын үеэр УУДБХОДТ-ийн ТУН-ээс 2016 оны 5, 6 дугаар сард ОХУ-д зохион байгуулах зөвлөлдөх уулзалтуудын төлөвлөгөөг танилцуулсан байна. ОХУ-ын Засгийн газар 2016 оны 4 дүгээр сарын сүүлээр уг саналд хариу өгнө гэсэн хүлээлттэй байсан.

11. Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тал дээр МУ-ын Засгийн газрын чадавх сайн байгаа нь санал хүсэлт бүрийг анхаарч үзэх явдлыг хангах үүднээс хариултын матриц хүснэгт боловсруулж, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах ба мэдээлэл түгээх удирдамж боловсруулж, УУДБХОДТ-ийн гомдол барагдуулах механизм боловсруулан олон нийтэд танилцуулж, Орхон болон Шүрэнгийн судалгааны ажилд хяналт тавих Олон улсын зөвлөх хороонд зориулж ажлын даалгаврын урьдчилсан хувилбарыг боловсруулсан зэргээс харагдаж байгааг Удирдлагын зүгээс онцолж байна.

12. ШУЦС болон ОГ төслийн БОННБҮ-ний ажлын даалгаврыг дахин хянах, шинэчлэх: Хяналтын хороо болон ЮНЕСКО-ийн тайланд багтсан санал, зөвлөмжүүд БОННБҮ-ний ажлын даалгаврыг дахин хянах, шинэчлэх ажлын үндэс суурийг бүрдүүлж байгаа гэж Удирдлага тэмдэглэв. Мөн түүнчлэн БНБОУ, БОННБҮ, ХНҮ-ний үе шатуудыг боловсруулж, судалгааны үргэлжлэх хугацаа, төсвийг нэмэгдүүлж, хамрах хүрээг тэлж Сэлэнгэ мөрний сав газар, Байгаль нуур, мөрний адаг хэсгийн намгархаг газруудыг

⁶ Удирдлагаас Монгол Улс: “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” ба “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл - Нэмэлт санхүүжилт”-ын талаар Хяналтын хороонд өгсөн Шинэчлэгдсэн мэдээний тэмдэглэл. Дэлхийн Банк. 2016 оны 5 дугаар сарын 17. Догол мөр 5.

багтаасныг Удирдлага тайлбарлав.

13. УУДБХОДТ-ийн цар хүрээг тодорхойлох зорилгоор 2015 оны 6 дугаар сард хийсэн томилолтод Банкны төлөөлөл оролцож, хэрэгжүүлэгч агентлагуудад техникийн туслалцаа үзүүлж, төслийн цахим хуудас дээр олон нийтэд танилцуулсан ажлын даалгаврыг хянаж, шинэчлэхэд дэмжлэг үзүүлсэн болохыг Удирдлага тайлбарлав. Зөвлөлдөх уулзалтуудын дараа ажлын даалгаврын урьдчилсан хувилбарыг хянаж үзээд, орос хэл рүү орчуулж, 2015 оны 10 дугаар сард болсон Монгол-Оросын хил дамнасан бүсийн хорооны уулзалтын үеэр ОХУ-ын БНБОЯ-ны төлөөлөгчдөд хүргүүлснийг Удирдлага мөн тэмдэглэв. Оросын төлөөлөгчид ажлын даалгаврыг тус яаманд албан ёсоор ирүүлэхийг хүссэний дагуу 2016 оны 2 дугаар сард хүргүүлсэн байна.

14. Одоогийн төлөв байдал: Удирдлага Банкны үйл ажиллагааны бодлого, тэр дундаа УАБ 4.01-ийг дагаж мөрдөх нь *“нэн чухал”* болохыг онцолж, *“нөлөөлөлд өртөж буй бүх хүмүүс, тэр дундаа ОХУ-д амьдарч буй нутгийн иргэдтэй зөвлөлдөх нь БОННБҮ-ний ажлын даалгаврыг эцэслэж, тодорхой болгох ажлын урьдач нөхцөл байх болно”* гэж мэдэгдэв.⁷ Зөвлөлдөх уулзалтуудыг Монголд хийж дууссан хэдий ч Монгол Улсын Засгийн газар Орос улсад зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах шаардлагатай хэвээр байгааг Удирдлага тайлбарлав.

15. УУДБХОДТ-ийн ТУН Москва хотод болсон мэргэжилтнүүдийн уулзалтын үеэр *“төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд”* болон Оросын ИНБ-уудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулахыг санал болгосон ба энэ саналын талаарх санал бодлыг нь сонсох үүднээс оролцогч талуудад түгээсэн болохыг Удирдлагын зүгээс тэмдэглэв. Удирдлага *“Монгол Улсын Засгийн газар зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах тухай албан ёсны хүсэлт гаргаж, ОХУ-ын Гадаад хэргийн яам тухайн хүсэлтийг хүлээж авсны дараа тэдгээр уулзалтыг зохион байгуулж, дуусгахад хэдэн сарын хугацаа шаардагдаж магадгүй”* гэж мэдэгдэв.⁸

16. *“Монгол Улс Оросын хамтрагч талуудыг татан оролцуулах тал дэр хичээл зүтгэл гаргаж, хил дамнасан бүсийн хорооны албан ёсны тогтмол уулзалтуудаар дамжуулан зөвлөлдөх уулзалтуудыг өндөр түвшинд хийж байгаагаа харуулсан”* болохыг Удирдлага тэмдэглэв.⁹ Үүнээс гадна “Орос Улсад зөвлөлдөх уулзалт зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрөх, бүх оролцогч талыг татан оролцуулахад хүчин чармайлт гаргах, хүлээн авсан санал хүсэлтүүдийг тусгах үүднээс ажлын даалгаврыг дахин хянаж, шинэчлэх тал дээр *“томоохон ахиц”* гарсныг Удирдлагын зүгээс тэмдэглэв.

17. Цаашдын төлөв байдал: *“Эрх баригчид хоорондын харилцаанд цаг их ордог”* тул Орос Улсад зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулахад илүү их цаг хугацаа шаардагдана гэдгийг Удирдлага тайлбарлав.¹⁰ Мөн түүнчлэн Орос, Монгол Улсын байгаль орчны яамдын төлөвлөгөөт уулзалтын үеэр УУДБХОДТ-ийн ТУН 2016 оны 5 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Буриад улсад зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай албан ёсны гэрээ

⁷ Мөн тэнд. Догол мөр 10.

⁸ Мөн тэнд. Догол мөр 11.

⁹ Мөн тэнд. Догол мөр 13.

¹⁰ Мөн тэнд. Догол мөр 14.

хэлэлцээр хийхийг зорьж байсныг тэмдэглэв. Банкны удирдлага “*Сибирийн өвөл эхлэхээс өмнө энэ үйл явцыг дуусгах боломжтой юм*” гэж мэдэгдэв.¹¹

18. **Хүсэлт гаргагчдын үзэл бодол.** Хүсэлт гаргагчид төслийг анхааралтай ажиглаж, Банк болон Хороотой байнгын харилцаатай байсаар ирсэн. 2015 оны 7 дугаар сард нийцтэй байдлын тайлан гарснаас хойш хүсэлт гаргагчид дараах асуудлуудыг хөндөж тавьсан юм. Үүнд:

19. **Зөвлөлдөх уулзалт, мэдээлэл түгээлт.** Хүсэлт гаргагчид Шүрэнгийн УЦС, Орхон-Говь төслийн БОННБҮ-ний ажлын даалгаврыг орос хэл дээр орчуулсныг таатай хүлээн авсан хэдий ч орчуулгын чанар, үүнээс улбаатай хүртээмжийн талаарх асуудлыг хөндсөн юм. Мөн Монгол Улсад зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтуудын тухайд бол хугацаа нь тулсан байхад зарласан, соёлын зохистой, хүртээмжтэй байдлаар явуулаагүй гэж мэдэгдсэн. Түүнчлэн, тэд төсөлд зохих хэм хэмжээ тогтоохын тулд олон нийтийг хамруулах, мэдээлэл түгээх хүрээ боловсруулахыг хүссэн юм. Эцэст нь, БОННБҮ болон техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн судалгааны харилцан холбоотой байдлыг харгалзан үзээд ТЭЗҮ боловсруулах ажлын шинэчлэгдсэн даалгаврыг нийтэд ил болгохыг хүссэн билээ. Эдгээр асуудлыг хөндөж тавихын зэрэгцээ зөвлөлдөх уулзалт зохион байгуулах үйл явцад ахиц гарсныг тэд мөн адил хүлээн зөвшөөрч байсан болно.

20. **БНБОУ ба БОННБҮ.** Хүсэлт гаргагчид БОННБҮ-ний ажлын даалгаварт БНБОУ-г багтаасныг таатай хүлээн авсан хэдий ч БНБОУ болон БОННБҮ-г тус тусад нь, өөр өөрийн гэсэн ажлын даалгавар, зөвлөлдөх уулзалт бүхий салангид үйл явц хэлбэрээр боловсруулахыг хүссэн юм. Эдгээрийг хамтад нь буюу ээлж дарааллаар бус боловсруулах нь дэд бүтцийн төлөвлөлтийн эхэн үед, тодорхой төслүүдийн талаар шийдвэр гарахаас өмнө шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах зорилго, өөрөөр хэлбэл БНБОУ хийх үндсэн зорилгод саад учруулна гэж тэд мэдэгдлээ. Түүнчлэн, Шүрэнгийн УЦС болон Орхон-Говь төслийн БНБОУ-ний тухайд бол Сэлэнгэ мөрний адаг хэсэгт хэрэгжихээр төлөвлөгдсөн бүх төсөл, тэр дундаа Эгийн голын УЦС-ын (Дэлхийн Банкнаас санхүүждэггүй) хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг (ХНҮ) багтаасан ажлын нэг даалгавар боловсруулахыг зөвлөмж болгосон.

В. Хорооны зүгээс хийсэн ажиглалтууд

21. 2015 оны 11 дүгээр сард Хорооны дарга Гонзало де ла Мата, Үйл ажиллагаа хариуцсан ажилтан Тамара Милзтайн нар ОХУ-ын Иркутск болон Байкальск хотноо зохион байгуулсан Сибирийн гол мөрнүүд сэдэвт хуралд оролцов. Хорооны ажлын хэсэг хүсэлт гаргагчид, Орос, Монгол Улсын ИНБ-ууд, Байгаль нуурын ус судлал, экологийн чиглэлээр ажилладаг судлаачид, Буриад улсын Байгалийн нөөц баялгийн яамны төлөөлөгчидтэй уулзав.

22. Хороо Шүрэнгийн УЦС, ОГ төсөл нь Сэлэнгэ мөрний адаг, Байгаль нуурын гидрологийн урсгал, усны түвшинд нөлөөлж, улмаар эдгээр экосистемийн экологийн эрүүл мэндэд нөлөө үзүүлж болзошгүй хэмээн санаа зовниж байгаа хүмүүсийн үзэл бодлыг сонсов. Хорооны ажлын хэсэгтэй уулзсан биологичид биологийн төрөл зүйл, ялангуяа

¹¹ Мөн тэнд. Догол мөр 17.

хилэм, омуль зэрэг загасны тоо толгойд үзүүлэх нөлөөллийн талаар санаа зовж байгаагаа илэрхийлж байв. Гидрологичид Байгаль нуур уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бөгөөд төслийн үйл ажиллагаа нь усны урсгалд нөлөөлж болзошгүй талаар санал бодлоо хуваалцав. Мөн тэд Орос, Монгол Улс усны нөөцийг хамтран ашиглах үндсэн хандлагыг тодорхойлох шаардлага байгааг онцлов.

23. Хүсэлт гаргагчид Сэлэнгэ мөрний адаг орчим болон Байгаль нуурын хүрээлэн буй орчинд нөлөө үзүүлэхээс гадна нуурын ойр орчимд оршин суудаг нутгийн иргэдийн ахуй амьдрал, тэдний соёлын өвд нөлөө үзүүлнэ гэж санаа зовж байгаагаа илэрхийлэв. Мөн тэд зөвлөлдөх уулзалтын үйл явц, ялангуяа БОННБҮ-ний ажлын даалгаврын орос хэл дээрх орчуулгын чанарт эргэлзэж буйгаа, мөн Орос улсад зохион байнуулсан зөвлөлдөх уулзалтын тоо хангалтгүй, ТЭЗҮ-г олон нийтэд ил болгосон байдал хангалтгүй зэрэг дутагдлын талаар ярьцгаав.

24. Буриад улсын Засгийн газрын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын үеэр ажлын даалгаврын орчуулга, санал бодлоо хуваалцах хугацаа хязгаарлагдмал байгаа талаар санаа зовж буйгаа хуваалцав. Мөн тэд ТЭЗҮ-ний ажлын даалгавар хүлээж аваагүй байгаагаа мэдэгдэж, ийм ажлын даалгаваргүйгээр БОННБҮ-ний ажлын даалгаврын талаар санал бодлоо хуваалцах нь хүндрэлтэй байгааг илэрхийлэв.

25. 2015 оны 11 дүгээр сараас хойш Хороо нь төслийн үйл явдал, өрнөлийг анхааралтай ажиглаж, Удирдлага болон хүсэлт гаргагчидтай харилцаа холбоотой байсаар ирсэн. Зөвлөлдөх явцад эерэг үйл явдлын өрнөл, арга хэмжээ, ялангуяа Шүрэнгийн УЦС болон Орхон-Говь төслийн БОННБҮ-ний ажлын даалгаврын талаар Орос дахь нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэдтэй зөвлөлдөх, Монгол дахь нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутгуудад зөвлөлдөх уулзалт зохион байгуулах шаардлага байгааг хүлээн зөвшөөрсөн зэрэг ахиц гарсныг Хороо тэмдэглэж байна. Хүсэлт гаргагчид Хороотой уулзаж ярилцахдаа энэхүү эерэг өөрчлөлтийг мөн адил хүлээн зөвшөөрч байв. Ажлын даалгаврыг шинэчилж, хүсэлт гаргагчдын хөндөж тавьсан зарим асуудлыг тусгасан гэж Хороо ойлгож байгаа бөгөөд Сэлэнгэ мөрний сав газарт ирэх 20 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүдэд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийдэг болох талаар Удирдлагын үүргийг тэмдэглэж байна. Түүнчлэн, Хороо нь эдгээр судалгааны бэлтгэл ажлыг хангахад зориулагдсан төсөв, хугацааг нэмэгдүүлж, үүндээ хоёр жил үргэлжлэх үйл явц, Хөндлөнгийн шинжээчдийн хорооноос зөвлөгөө авах зэргийг тусгасан гэдгийг тэмдэглэж байна. Байгаль нууртай холбоотой үйл ажиллагаа, шийдвэрийн талаар мэдээлэх үүднээс Хороо ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хөтөлбөртэй харилцаа холбоотой ажиллаж байна.

26. Тодорхой ахиц гарсан хэдий ч хүсэлт гаргагчдын хөндөж тавьсан асуудлуудыг шийдвэрлэх хэд хэдэн арга хэмжээ батлагдахаар хүлээгдэж байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэмэлт цаг хугацаа шаардагдах болно. Ялангуяа Орос улсад зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах тухайд бол тэдгээр уулзалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх талаар хоёр талын хэлэлцээр хийж, хоёр улсын хооронд албан ёсны гэрээ байгуулах шаардлагатай. Энэ утгаараа санал болгож буй арга хэмжээнүүд бүрэн хэрэгжих хүртэл нэмэлт цаг хугацаа шаардагдана.

Г. Зөвлөмж

27. Өмнөх хэсэгт дурдсанчлан хүсэлт гаргагчдын хөндсөн асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн арга хэмжээ хүлээгдэж байгаа бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхэд нэмэлт цаг хугацаа шаардагдана. Иймээс Удирдлагын зүгээс хянан шалгалт хийлгэх хүсэлтэд хөндөгдсөн хууль журмын хэрэгжилт, хор хохирлын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд үнэлгээ хийхийн тулд Хороо хэсэг хугацаанд харзнаж, ахиц гарахыг хүлээх шаардлагатай болно.

28. Хороо нь дээр дурдсан зүйлс болон 1999 оны Тодруулгын¹² 5 дахь догол мөрийг харгалзан үзсний үндсэн дээр хоёрдахь удаагаа хойшлуулахыг зөвлөмж болгоод, БОННБҮ-ний ахиц, хамрах хүрээ, мөн Монгол, Орос Улсад хоёуланд нь зохион байгуулагдсан зөвлөлдөх уулзалтын үйл явцын чанарыг үнэлсний дараагаар нэг жилийн дотор Зөвлөлд тайлагнах болно. Тэр үед Банкны үйл ажиллагаанд хяналт, шалгалт оруулах шаардлагатай эсэх талаар зөвлөмж гаргах юм.

¹² “1999 оны Тодруулга”-ын 5-р догол мөрөнд “Хяналтын хороо нь Банкны зүгээс нийцүүлсэн эсвэл нийцүүлэх санаатай байгааг нотлох нотолгоо нь зохих эсэхээс үл хамааран өөрсдийн шаардлагыг хангаж, Зөвлөлд тайлагнахдаа энэ үнэлгээг тусгах болно” гэж заасан байдаг.

Хавсралт I

**Монгол Улс: “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг
дэмжих төсөл (P118109)”**

**“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл –
Нэмэлт санхүүжилт (P145349)”**

**Хянан шалгалт хийлгэх хүсэлтийн хариуд
Хяналтын хорооноос гаргасан тайлан ба зөвлөмж
2015 оны 7 дугаар сарын 2**

Хяналтын хороо

Хяналтын хороонд ирүүлсэн хүсэлтийн хариуд гаргасан тайлан ба зөвлөмж

Монгол Улс: Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109) Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл - Нэмэлт санхүүжилт (P145349)

А. Удиртгал

1. 2015 оны 2-р сарын 10-ны өдөр Хяналтын хороо (цаашид “Хороо” гэнэ) Монгол Улс, ОХУ-ын орон нутгийн байгууллага болон иргэдийн төлөөллөөс хянан шалгалт хийлгэх хүсэлт (цаашид “Хүсэлт” гэнэ) хүлээн авсан. Дээрх бүлгүүд “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” (P118109) болон “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл - Нэмэлт санхүүжилт” (P145349) (цаашид эдгээр 2 төслийг “УУДБХОДТ” эсвэл “Төсөл” гэнэ) төслийн дор санхүүжиж буй үйл ажиллагааны улмаас учирч болзошгүй хор хохиролтой холбоотой ноцтой асуудлуудыг хөндөж тавьсан юм. Хүсэлт гаргагчид Хорооноос тэдний хувийн нууцыг хадгалахыг хүссэн бөгөөд “Хил хязгааргүй гол мөрөн” байгууллагаас уг хүсэлтэд хамаарах асуудлаар харилцаж байх 2 хүнийг Монгол, Орос Улсад төлөөлүүлэн томилсон байна.

2. Хүсэлтэд Дэлхийн Банк Монголын Сэлэнгэ мөрөн болон ОХУ-ын нутаг дахь Байгаль нуурын усны нөөцөд эргэж нөхөгдөшгүй нөлөө үзүүлж болзошгүй төслүүд буюу санал болгож буй Шүрэнгийн усан цахилгаан станц төсөл (Шүрэнгийн УЦС) болон Орхон-Говь ус дамжуулах төслийн (ОГТ) үнэлгээний судалгааг дэмжиж байна гэж дурьджээ.

3. Хороо 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хүсэлтийг бүртгэн авч, Банкны удирдлага болон Гүйцэтгэх захирлын зөвлөлд (цаашид “Зөвлөл” гэнэ) мэдэгдсэн. Удирдлага 2015 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр хариу ирүүлсэн. Албан ёсны томилолтын үеэр Хороо Монгол улс болон ОХУ-ын нутагт оршин сууж буй нутгийн иргэдээс дээрх хүсэлтэд нэмж оруулах баримтуудыг хүлээн авсан юм.

4. 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Хороо нь хүсэлтэд дурдсантай төстэй асуудлыг хөндсөн илтгэл буюу санал болгож буй Орхон-Говь төсөл болон Шүрэнгийн УЦС төслийн үйл ажиллагаанаас Байгаль нуурт (Дэлхийн өвд бүртгэгдсэн газар) учрах эрсдэлийн талаарх ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хөтөлбөрийн илтгэлтэй танилцах үүднээс энэ тайланг илгээх хугацааг 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хойшлуулж өгөхийг Зөвлөлөөс хүссэн юм.

Б. Төсөл

5. УУДБХОДТ нь Олон улсын хөгжлийн агентлагийн зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх техникийн туслалцааны үйл ажиллагаа бөгөөд 2011 оны 5 дугаар сарын 10-нд Зөвлөл 25 сая ам.долларын төсөв баталсан ба 2016 онд дуусахаар төлөвлөгдсөн. 2014 онд

4.2 сая ам.долларын нэмэлт санхүүжилт батлагдсан. Төслийн хөгжлийн зорилтууд нь “санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхийг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг бэлтгэж, хэрэгжүүлэх дотоодын чадавхийг нэмэгдүүлэхэд орших” юм.¹ Монгол улсын Сангийн яам төслийн хэрэгжилтийг хариуцах бөгөөд удирдлага нь Төслийн удирдах хороонд (ТУХ) төвлөрнө. ТУХ-ны гол үүргийн нэг бол УУДБХОДТ-ийн хүрээнд үнэлэх дэд төслүүдийг тодорхойлж, санал болгох явдал юм.

6. УУДБХОДТ нь: (i) дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих, (ii) чадавхийг бэхжүүлэх, мэдлэг шилжүүлэх, (iii) гүний усны менежментийг сайжруулах, (iv) төслийн менежмент² гэсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй. Хүсэлт ерөнхийдөө 1-р бүрэлдэхүүн хэсгийн талаар авч үзжээ. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Төсөл нь урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ болон байгаль орчны үнэлгээний судалгаа зэргийг багтаасан Монголын уул уурхайн салбарын хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн дэд төслүүдийн төрөл бүрийн үнэлгээний ажлыг санхүүжүүлж байгаа юм. УУДБХОДТ-ийн Төслийн үнэлгээний баримт бичигт (ТҮББ) дурдсанаар эрчим хүч, тээвэр, мэдээллийн технологи, холбоо харилцаа, усан хангамж, орон сууц, нийгмийн хөгжил, ложистик, хилийн боомтын байгууламж зэрэг салбарын төслүүд дэмжигдэх боломжтой юм.

7. Төслийн хэрэгжилтийн явцад тодорхой дэд төслүүд тодорхойлогдоход Банкны хамгааллын бодлогын хүрээний сонголтыг дэд төслийн түвшинд гүйцэтгэх болно гэж ТҮББ-г дурдсан байна. Бэлтгэл ажил, үнэлгээний явцад зөвхөн Байгаль орчны үнэлгээний (БОУ) бодлогын эхлэл тавигдсан бөгөөд дэд төслийн түвшний хамгааллын бодлогын шалгуур үзүүлэлтийг тогтоох, хамгааллын бодлоготой холбогдох шаардлагуудыг тодорхойлох үүднээс “Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээг” (БОНУХ) боловсруулахад хүргэсэн юм. Энэ төсөл нь А категорид хамаарна.

8. Төслийн баримт бичгийн өөрчлөлт. 2014 оны 4 дүгээр сарын 14-нд Зөвлөл УУДБХОДТ-ийн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийг баталсан.³ Төслийн хөгжлийн зорилтууд өөрчлөгдөөгүй үлдсэн хэдий ч дараах хамгааллын таван нэмэлт бодлогыг эхлүүлэхээр болсон. Эдгээрт байгалийн амьдрах орчин, соёлын өвийн биет нөөц, албадан нүүлгэн шилжүүлэлт, далангийн аюулгүй байдал, олон улсын усан замын бодлого багтана. Эдгээр нь сонгогдсон дэд төслүүдийн ТЭЗҮ-г боловсруулах үе шатанд хамаарна. Түүнчлэн БОНУХ-г шинэчилж, төслийн гүний усны бүрэлдэхүүн хэсгийг цар хүрээг өргөжүүлжээ.

9. ТУХ нь төслийн шинэчилсэн баримт бичигт УУДБХОДТ-ийн хүрээнд үнэлэгдэх зургаан дэд төслийг тодорхойлсон байна. Эдгээрээс хоёр нь хянан шалгалт хийлгэх хүсэлтэд дурдагдсан Шүрэнгийн УЦС болон Орхон-Говь төслүүд⁴ юм. Баримт бичигт төслийн үнэлгээний судалгаа нь (i) төслийг БОНУХ-нд нийцүүлэн тодорхойлж, сонгох, (ii) урьдчилсан ТЭЗҮ судалгаа, (iii) Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн байдлын үнэлгээг (БОННБҮ) багтаасан ТЭЗҮ судалгаа гэсэн гурван үе шаттай явагдах талаар тусгажээ.

¹ Төслийн үнэлгээний баримт бичиг. Монгол Улсын Уул уурхайн дэд бүтцийг хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл. 2011 оны 4 дүгээр сарын 7. (ТҮББ) : 4.

² ТҮББ: 5.

³ Төслийн баримт бичиг, УУДБХОДТ, 2014 оны 3 сарын 18.

⁴ ТҮББ3-р тал, 9

10. Төслийн төлөв байдал. Шүрэнгийн УЦС болон Орхон-Говь төслийн (i), (ii)-р үе шат бүрэн хэрэгжсэн болно. ТЭЗҮ судалгааны ажлын даалгаврын төсөл боловсруулагдсан бөгөөд эдгээр судалгааг хийх зөвлөхүүдийг сонгон шалгаруулах олон улсын тендерийн үйл ажиллагаа явагдаж байна. Эдгээр дэд төслийн БОННБҮ-ний ажлын даалгаврыг эцэслэн боловсруулж байна.

11. *Шүрэнгийн УЦС.* Урьдчилсан ТЭЗҮ судалгааны явцад Сэлэнгэ мөрөн дээрх Шүрэнгийн УЦС-ын байршлын хувилбарын тоо хоёр болтлоо буурч, өртөг нь 350-782 сая ам.долларын хооронд хэлбэлзэж, суурилуулах тоног төхөөрөмжийн хүчин чадал 160-240 MW хооронд байхаар авч үзжээ. УЦС нь Монгол улсын нутаг дэвсгэрт байрлаж, харин урсгал өөд 500 км сөрөхөд Сэлэнгэ мөрний адаг болон Байгаль нуурт хүрэх ба эдгээр нь хоёулаа ОХУ-ын нутагт оршино. УЦС-ын тодорхой байршлыг ТЭЗҮ судалгаагаар тогтооно. Далангийн ус хуримтлуулах талбай нь Сэлэнгэ мөрний адаг хэсэг (Рамсарын конвенцид орсон газар), Байгаль нуурын (ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн жагсаалтанд бүртгэгдсэн газар) урсгалд нөлөөлөх газрын нэг хэсэг юм. Шүрэнгийн УЦС-ын зорилго нь уул уурхайн салбарыг эрчим хүчний тогтвортой эх үүсвэрээр хангах, мөн нүүрснээс хэт хамааралтай байгаа одоогийн Монгол Улсын цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжихэд оршино.

12. *Орхон-Говь ус дамжуулах төсөл* нь гадаргын усыг хуримтуулах, урсацын тохируулга хийх зорилгоор Орхон гол дээр далан, усан сан байгуулах ажлуудаас бүрдэнэ. Үүнд 900-1000 км урттай дамжуулах хоолой ашиглан усыг Өмнөд Говийн бүс нутаг руу дамжуулах ажил багтах юм. Төлөвлөсөн зардал нь 600 саяас 1 тэрбум ам.долларын хооронд байна. Энэхүү төсөл нь нутгийн оршин суугчид болон уул уурхайн салбарыг усны тогтвортой эх үүсвэрээр хангах, аль хэдийнэ багасаад байгаа гүний усны нөөц ашиглалтыг бууруулах зорилготой юм.

В. Хүсэлт

13. Хүсэлтийг товчлон доор нэгтгэв. Хүсэлт гаргагчдын анхаарлаа хандуулсан асуудлыг энэхүү тайлангийн “Ажиглалт” хэсэгт нарийвчлан тусгав. Хавсралт 1-д хүсэлтийг бүрэн эхээр нь оруулав.

14. Хүсэлтэд Дэлхийн банкнаас санхүүжүүлсэн болон санхүүжүүлэх УУДБХОДТ-ийн 1-р бүрэлдэхүүн хэсэгт багтсан “Орхон голын орон нутгийн болон урсгалыг зохицуулах төсөл” (төслийн баримт бичигт Орхон-Говь ус дамжуулах төслийг ингэж нэрлэсэн) болон Шүрэнгийн УЦС гэсэн хоёр дэд төслийн урьдчилсан болон эцсийн ТЭЗҮ судалгаа нь Монгол болон ОХУ-ын оршин суугчид, байгаль орчинд эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны залруулж болшгүй нөлөө үзүүлж болохыг дурьджээ.

15. Хүсэлт гаргагчид хил дамнасан болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ зэргийн сонгон шалгаруулалт хийсэн байдал нь тодорхой биш, олон хувилбар болон эрсдэлийн үнэлгээнд суурилагагүй зэргээр дэд төслүүдийг тодорхойлохдоо Банкны бодлогыг зөрчсөн гэсэн нэхэмжлэл гаргасан. Тэд мөн урьдчилсан ТЭЗҮ судалгаа зэрэг төслийн баримт бичгийг олон нийтэд ил болгоогүй, дэд төслүүдийн үйл ажиллагаанд өртөх оршин суугчдад

болон иргэний нийгэмд хандсан зөвлөлдөх уулзалт нь хангалтгүй байсан гэж үзжээ.

16. Байгаль нуур болон Сэлэнгэ мөрний экосистем “дэлхийн байгаль хамгаалалд нэн чухал ач холбогдолтой” болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг, мөн Сэлэнгэ мөрөн, Орхон гол нь хоёулаа байгалийн нэн чухал амьдрах орчныг бүрдүүлдэг байхад чухамхүү яагаад заавал Шүрэнгийн УЦС болон Орхон Говь төслийг сонгох болсныг тодруулахыг хүсчээ. Түүнчлэн 2009 онд хийгдсэн Өмнөд говийн уул уурхайн салбарын эрчим хүчний эх үүсвэрийн судалгаанд Банк нь усан цахилгаан станцыг уул уурхайн үйлдвэрлэлд шууд хамааралтай гэж үзээгүй тул Шүрэнгийн УЦС нь уул уурхайн салбарт шууд хамааралгүй гэж үзэж байгаагаа тэд дурджээ.

17. Хүсэлтэд Шүрэнгийн УЦС болон Орхон-Говь төслийн үйл ажиллагаа нь Монгол Улс, ОХУ-ын орон нутгийн иргэд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж, үүний улмаас усны амьтдын чөлөөт нүүдэл багасч, загасны нөөц буурч, урсгал усны шим тэжээл, тунадасны хэмжээ алдагдаж, урсацын хэмжээ багасч, байгалийн усны хэм өөрчлөгдөж (энэ нь эрүүл мэндийн эрсдэл дагуулдаг), байгалийн нэн чухал амьдрах орчин алдагдаж, хүлэмжийн хийн ялгаруулалт ихсэж, Байгаль нуур доройтож болзошгүй гэдгийг тайлбарлажээ. Эдгээр төслийг хэрэгжүүлснээр Монголын өмнөд хэсгээр нутаглан мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчин түмэн ус, бэлчээр ашиглах боломжгүй болох, усан сангийн үерлэлтийн улмаас тариалангийн талбай, бэлчээрийн нөөцийг ашиглах боломжгүй болох, эко аялал жуулчлал явуулах боломжгүй болох, Байгаль нуур гэх мэт ариун дагшин, соёлын өндөр ач холбогдолтой түүх, археологийн дурсгалт газрууд устаж алга болох зэрэг нийгэмд үзүүлэх ноцтой хор хохирлуудыг дурдсан байна.

18. Хүсэлтэд Дэлхийн Банк нь Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт, Байгалийн амьдрах орчин, Байгаль орчны үнэлгээ, Олон улсын усан зам, Мэдээллийн хүртээмжтэй байдал, Усны нөөцийн удирдлага, Албадан нүүлгэн шилжүүлэлт, Соёлын өвийн биет нөөц зэрэг бодлогыг мөрдөж ажиллаагүй гэж үзсэн байна.

Г. Удирдлагын хариулт

19. Удирдлагын хариултыг товчлон доор нэгтгэв. Хариултын бүрэн эх уг тайлангийн Хавсралт 2-д бий.

20. Удирдлага УУДБХОДТ нь нүүрс, зэс, алт, уран болон төмрийн хүдрийн ордоороо дэлхийн хамгийн баян орны хувьд Монгол орны уул уурхайн үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэхэд чиглэгдсэн дэд бүтэц болон хууль эрх зүйн хүрээг бий болгох стратегийн дэмжлэгийн нэг хэсэг болохыг хариундаа тэмдэглэсэн юм. Энэ утгаараа УУДБХОДТ нь Засгийн газарт томоохон хэмжээний дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхдээ олон улсын шилдэг туршлага болон Банкны бодлого, журмыг дагах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг багтаасан байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийхэд нь туслах зорилготой юм. Тиймээс УУДБХОДТ-ийн хүрээнд сонгогдсон дэд төслүүдийг үнэлэх, судлах үйл явц дахь Банкны оролцоо нь ил тод байдал, системтэй хандлага, чадавхийг нэмэгдүүлэх болно гэж Удирдлагын зүгээс үзэж байна. Эцсийн зорилго нь мэдээлэлд суурилсан, тогтвортой шийдвэр гаргах явдлыг хангах үүднээс иж бүрэн, системтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа явуулахад нь Монгол Улсад туслах явдал юм.

21. Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ) нь УУДБХОДТ-ийн хүрээнд бэлтгэгдсэн. Цаашид УУДБХОДТ-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжих төсөл, судалгааны ажлуудыг БОНУХ-нд нийцүүлдэг болно гэж БОНУХ-д тусгайлан заажээ. Удирдлага *“БОНУХ-ын зорилго нь аливаа санхүүжүүлэгч Монголын байгаль орчин, нийгмийн салбарын хууль тогтоомж болон Дэлхийн Банкны байгаль орчны хамгааллын бодлогыг мөрдөж, байгаль орчин, нийгэмд нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, нөлөөллийг бууруулах, арилгах асуудалд анхаарал хандуулж, зохих арга хэмжээг тодорхойлдог байх явдлыг хангахад оршино”*⁵ гэдгийг тэмдэглэв.

22. *Дэд төслүүдийн сонголт.* Удирдлага хариултандаа УУДБХОДТ-ийн тусламжтайгаар үнэлэгдэх дэд төслүүдийг хэрхэн сонгож, үнэлсэн үйл явцыг тайлбарласан байна. Мөн ТҮББ-т төслийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Төслийн удирдах хороо (ТУХ) байгуулагдсаныг дурджээ. Уг хорооны үүрэг хариуцлагын нэг бол УУДБХОДТ-ийн хүрээнд үнэлэгдэх дэд төслүүдийг тодорхойлж, шийдвэр гаргах явдал юм. ТУХ нь энэхүү хүсэлтэд дурдсан Шүрэнгийн УЦС болон Орхон Говь төслийг оролцуулаад нийт зургаан дэд төслийг сонгон шалгаруулсан. Банк 2014 оны 11 дүгээр сард эдгээр сонгогдсон дэд төсөл УУДБХОДТ-ийн зорилго, цар хүрээнд нийцэж байгааг баталгаажуулж, олон улсын зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр дэд төсөл нэг бүрийн техникийн судалгаанд хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан. ТУХ нь УУДБХОДТ-өөс дэмжигдсэн дэд төслийн үйл ажиллагааг явуулах журам гаргасан. Шүрэнгийн УЦС болон Орхон Говь төсөл нь дараахь гурван үе шаттай чиг хандлагыг баримтална. Үүнд 1-р үе шатанд техник, санхүү, байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд урьдчилсан байдлаар шинжилгээ хийх, 2-р үе шатанд урьдчилсан ТЭЗҮ судалгаа явуулах, 3-р үе шатанд ТЭЗҮ судалгаа, байгаль орчин, нийгэмд нөлөөлөл байдлын үнэлгээ хийх ажлууд багтана. 3-р үе шатанд “оролцогч талуудыг хамарсан, олон нийттэй зөвлөлдөх уулзалтуудыг Дэлхийн Банкны бодлого, журамд нийцүүлэн зохион байгуулах болно” гэж Удирдлага мэдэгдсэн.⁶

23. *УУДБХОДТ-ийн цар хүрээ болон үйл явц.* УУДБХОДТ-ийн хүрээнд сонгогдсон дэд төслүүд төслийн хамрах хүрээг зөрчсөн гэх нэхэмжлэлтэй санал нийлэхгүй байгаагаа Удирдлагын зүгээс илэрхийлэв. Үнэлэхээр сонгосон дэд бүтцийн төрөлд УУДБХОДТ-ийн төслийн зорилгод заасанчлан уул уурхайн салбарын хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай алхам буюу эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтууд багтсан гэж мэдэгджээ. УУДБХОДТ-ийн дэмжсэн үйл явцын тухайд бол томоохон хэмжээний дэд бүтцийн төслүүдэд олон улсын шилдэг туршлага, Дэлхийн банкны бодлого, журмыг дагаж мөрддөг тул тогтвортой үйл явц мөн гэдгийг нэмж тэмдэглэж байна. Дээр дурьдсанчлан Шүрэнгийн УЦС болон Орхон Говь төслийн судалгааг явуулахдаа гурван үе шаттай хандлагыг баримталсан. Эхний үе шатанд магадлан шинжилгээний тайлан, мөн 2-р үе шатанд хийгдэх урьдчилсан ТЭЗҮ судалгааны ажлын даалгаврыг боловсруулсан юм. Удирдлага “шийдвэрийг ТУХ болон Банк гаргана” гэж журамд заасныг дурдаж байна. ТУХ-оос ТЭЗҮ боловсруулах үе шатыг эхлүүлэхийг санал болгосон боловч Банк 2014 оны 11 дүгээр сард Шүрэнгийн УЦС, Орхон Говь төслийн урьдчилсан ТЭЗҮ, бэлтгэл судалгааг тус бүр “шаардлага хангасан” хэмжээнд хийж дууссаны дараа баталгаажуулахаа мэдэгдсэн.

⁵ Удирдлагын хариу: 11

⁶ Удирдлагын хариу: 12

24. Удирдлага Банкны бодлогын дагуу оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтыг Үнэлгээний судалгааны гүйцэтгэлийн дараагаар зохион байгуулах болно хэмээн хариултандаа мөн тэмдэглэсэн байна. Түүнчлэн санал болгож буй дэд төслүүдийг хянах Шинжээчдийн баг байгуулан ажиллах болно.

25. *Хувилбаруудын шинжилгээ.* Хариултанд УУДБХОДТ-ийн хүрээнд бусад хувилбарыг шинжлэн дүгнэх үйл явц нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн томоохон хэмжээний дэд бүтэц барьж байгуулах үйл явц болохыг тэмдэглэсэн байна. Шүрэнгийн УЦС-ын хувьд хувилбаруудын анхны шинжилгээ нь Монгол дахь эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх судалгааны ажил буюу Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Эрчим хүчний салбарын төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн юм. Санал болгож буй Шүрэнгийн УЦС-ын төслийн үндсэн хоёр хувилбар нь нүүрс хэрэглэдэг эрчим хүчний үйлдвэрүүдийг хөгжүүлж, ОХУ-аас авдаг эрчим хүчний импортыг нэмэгдүүлнэ гэж уг төлөвлөгөөнд үзжээ. Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд эдгээр хувилбарыг “эдийн засаг, санхүүгийн хувьд хамгийн боломжит өрсөлдөхүйц нөхцөл” хэмээн тодорхойлжээ. Энэхүү төлөвлөгөөнд нүүрс хэрэглэдэг станцуудтай харьцуулахад усан цахилгаан станц нь үр ашигтай бөгөөд оршин тогтнох чадвартай тул Сэлэнгэ мөрөн дээрх усан цахилгаан станцыг хөгжүүлэх нь хамгийн чухал хэмээн санал болгосон байна. Түүнчлэн төлөвлөгөөнд салхи, нарны эх үүсвэр нь усан болон нүүрсэнд суурилсан эрчим хүч үйлдвэрлэлийг бүрэн орлож чадахгүй гэдгийг дурьдсан байна. Удирдлага энэхүү судалгааны үнэлгээний нөхцлийг цаашид хэрэглэж болохыг тэмдэглэж байна.

26. Нүүрсээр галладаг станцууд болон импортын эрчим хүчийг нэмэгдүүлэх нь санал болгож буй Шүрэнгийн УЦС-ын урьдчилсан ТЭЗҮ судалгааны үед харьцуулах хамгийн боломжит нөхцөл байсан. Сүүлд нь Сэлэнгэ мөрөн дээрх усны эрчим хүч үйлдвэрлэлийн хөгжлийн байршлуудын хувилбар тус бүрд нь шинжилгээ хийн тодорхойлсон байна. Урьдчилсан ТЭЗҮ судалгаа нь Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд Шүрэнгийн УЦС-ын хөгжлийн тэргүүлэх ач холбогдлыг тодорхойлсон зөвлөмжийг баталгаажуулсан байна. Энэхүү боломжит хоёр нөхцлийг хэлбэрийн хувьд тодорхойлсон бөгөөд цаашид энэхүү хоёр байршлын ТЭЗҮ судалгааг үргэлжлүүлэхийг санал болгожээ. Удирдлага ТЭЗҮ болон БОННБҮ-ний ажлын даалгаварт эдгээр зөвлөмжийг багтаасан болохыг тэмдэглэж байна.

27. Орхон Говь төслийн хувьд, бэлтгэл судалгаа нь Өмнөд говийн бүс нутаг дахь гүний усны нөөц болон усны хэрэгцээнд шинжилгээ хийх боломж олгосон юм. Үр дүнд нь гүний усны нөөц нь дарагдмал бөгөөд нөхөн сэргээгддэггүй, усны хэрэгцээ өсч байгааг тодотгохын зэрэгцээ Өмнөд говийн бүсийн усны хангамжийг урт хугацаанд хангахад Орхон говь төсөл нь цаашдын үнэлгээний ач холбогдлыг онцолсон байна. Орхон Говь төслийн үнэлгээний судалгаа нь эрчим хүчний эх үүсвэрээс илүүтэйгээр усан хангамжийн эх үүсвэрийн асуудалд түлхүү анхаарсан байна. Урьдчилсан ТЭЗҮ судалгааг үргэлжлүүлэхийн өмнөх шатанд нарийвчилсан бэлтгэл судалгаа нь санал болгож буй төслийн нарийн төвөгтэй, тодорхойгүй байдлыг тодруулахад чиглэсэн байна. Усан хангамжийн хувилбарт нөхцлүүдийг шинжилсэн бөгөөд Орхон голоос хоолойгоор ус татах болон орон нутгийн гүний усны эх үүсвэрийг ашиглах гэсэн хоёр хувилбарыг хослуулах нь хамгийн шилдэг шилдэг арга зам болохыг тогтоосон байна. Энэ судалгааны талаар Орхон Говь төслийн урьдчилсан болон эцсийн ТЭЗҮ судалгааны ажлын даалгаварт тэмдэглэсэн

байна.

28. *Хуримтлагдах нөлөөллийн шинжилгээ.* Удирдлага санал болгож буй Шүрэнгийн УЦС-ын БОННБҮ нь ирээдүйд Сэлэнгэ мөрний дэд бүтцийн хөгжлөөс хуримтлагдах нөлөөллийн шинжилгээг багтааж байгааг тэмдэглэж байна. Мөн Удирдлага энэхүү шинжилгээнд дараагийн жилийн хугацаанд усны эрчим хүчний дэд бүтцээс үүсэлтэй Байгаль нуур болон Сэлэнгэ мөрөн дээрх байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, доод урсацын дагуу байршилд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ багтаж байгаа талаар нэмж дурдаж байна. Дэд төслүүд хэрэгжсэн тохиолдолд БОННБҮ-нд төслүүдийн нөлөөг хянах, багасгах болон боломжит нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нарийвчилсан Байгаль орчны удирдлагын төлөвлөгөө мөн багтах юм.

29. *Орхон Говь төслийн БОННБҮ.* Хариултад Орхон Говь төслийн БОННБҮ-ний хүрээнд Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ болон төслийн бусад хэсгүүдэд зориулсан гурван тусдаа БОННБҮ (усны урсгалыг зохицуулах бүтэц ба усан сан, ус дамжуулах хоолой, шахуургын станц ба усны эрчим хүчний хэрэгсэл, эрчим хүч дамжуулах шугам)-г багтаасан хэд хэдэн ялгаатай үнэлгээ хийгдэх талаар дурджээ. Хариултад дурьдсаны дагуу эдгээр шинжилгээнүүд нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, дахин суурьшуулалтын төлөвлөгөө болон шаардлагатай тохиолдолд нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөөний бэлтгэлийг агуулах болно

30. *Хил дамнасан нөлөөллүүд.* Орхон гол нь Сэлэнгэ мөрний цутгал, улмаар ОХУ-ын нутаг дахь Байгаль нуурт цутгадаг тул санал болгож буй Шүрэнгийн УЦС, Орхон Говь төслүүд хил дамнасан нөлөө үзүүлэх нь гарцаагүй болохоор УУДБХОДТ-д Банкны олон улсын усан замын талаар баримтлах бодлого (ҮАБ 7.50) тохирно гэж Удирдлага үзэж байна. Эрэг орчмын бүсийн оролцогчдод мэдэгдэл хүргүүлэх тухай ҮАБ 7.50 дахь шаардлагыг УУДБХОДТ-ийн нэг хэсэг болгон хэрэгжүүлээгүй юм. Банкны удирдлага бодлогодоо онцгой тохиолдолд “санхүүжүүлэхээр төлөвлөсөн төслийн үйл ажиллагаанаас үүссэн нөхцөл байдлыг анхааралдаа авна” гэж баталсан байна. Удирдлага санал болгож буй хоёр төслийн БОННБҮ-ний ажлын даалгаварт эрэг хавийн оролцогчидтой холбогдолтой байж болзошгүй асуудлын шинжилгээг багтасныг дурдсан байна.

31. Удирдлага Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрууд хоёр дэд төсөл болон тэдгээрийн болзошгүй нөлөөллийн талаар хоёр талын хамтарсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан талаар мэдэгдсэн. 2014 оны 8 дугаар сард Монгол Улс, ОХУ-ын ШУА хооронд үнэлгээний судалгааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зуржээ. 2015 оны 3 дугаар сард ОХУ-ын төлөөлөгчид Монголын холбогдох байгууллагуудтай уулзалт хийсний үр дүнд Шүрэнгийн судалгааны хамтын ажиллагааны протокол зурагдсан.

32. *Байгаль нуур ба Сэлэнгэ мөрний адаг.* Удирдлага дээрх хоёр газар нь Дэлхийн өвийн конвенци болон Рамсарын конвенцийн аль алинд нь тусгагдсан чухал газар болохыг хүлээн зөвшөөрсөн. УУДБХОДТ-өөр дамжуулан Банк Монгол Улсын олон улсын гэрээний нөхцөлд заасан үүрэгт хамаарах үйлдэлд шинжилгээ хийсэн. Удирдлага УУДБХОДТ-ийн хүрээний үйл ажиллагаа нь Дэлхийн өвийн хорооны шийдвэрийн шаардлагын дагуу дэд төслүүдийг зохих ёсоор үнэлсэн ба үнэлгээний үр дүнг олон нийтэд нээлттэй хүргэх юм.

Удирдлага хэрэв Үнэлгээний судалгаагаар санал болгож буй дэд төслүүд нь ноцтой өөрчлөлт, байгалийн амьдрах орчны доройтолд хүргэх нь тогтоогдвол Байгалийн амьдрах орчин ҮАБ 4.04-т заасны дагуу Банкны зүгээс Монгол Улсын Засгийн газарт дэд төслүүдийг цаашид үргэлжлүүлэхгүй байхыг зөвлөмж болгоно.

33. *Зөвлөлдөх уулзалт ба мэдээллийг түгээх.* Удирдлага УУДБХОДТ нь Банкны бодлого, журамд заасны дагуу хэрэгжиж байгаа болохыг мэдэгдэж байна. Төслийн баримт бичиг нь англи хэл дээр тараагдсан ба дэд төслүүдийн ажлын даалгавар нь УУДБХОДТ-ийн БОНУБ-ны хамт монгол хэлээр орчуулагдсан байна. Банкны бодлогын дагуу урьдчилсан ТЭЗҮ судалгааг түгээхэд Монгол Улсын Засгийн газар нь давуу эрхтэй бөгөөд, Удирдлага Бодлогын баримт бичигт тусгасны хажуугаар мэдээллийг түгээх ажилд Засгийн газарт аль болох дэмжлэг үзүүлж байсан болно. Банк мөн Төслийн удирдлагын баг, орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнууд, санаа зовсон оролцогч талууд, тэр дундаа хүсэлт гаргагчдыг төлөөлж буй 1 хүн зэрэг оролцогч талууд хоорондоо харилцах, зөвшилцөх явдалд дэмжлэг үзүүлсэн.

34. БОННБҮ-ний ажлын даалгаврын талаарх зөвлөлдөх уулзалт 2015 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулагдсан юм. Удирдлага эдгээр үйл ажиллагаанд холбогдох талуудын оролцогчдын тоог “хангалттай”, бөгөөд цаашдын зөвлөлдөх уулзалтуудыг төслийн нөлөөлөлд нэрвэгдэх орон нутгийн иргэдийг хамруулах байдлаар зохион байгуулна гэдгийг тэмдэглэж байна. Банк санал болгож буй Шүрэнгийн УЦС-ын БОННБҮ-ний үйл ажиллагааны явцад олон нийтийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах цагийн хуваарь, шинжээчдийн багийг иргэдтэй хамтран ажиллах боломж олгох “зөвлөлдөх уулзалтын замын зураг” боловсруулахад төсөлд мөн тусалсан. Удирдлагын шийдвэрийн дагуу, зөвлөлдөх уулзалтууд нь дэд төслийн нөлөө үзүүлэх орон нутгийн оролцогчдыг тэмдэглэсэн байр зүйн зураглалыг үндэслэн “улсын хилийн заагаас үл хамааран” доод урсацын дагуу нэрвэгдсэн бүлгүүдийг хамруулан Оросын нутаг дэвсгэрт мөн зохион байгуулах юм.⁷

35. Удирдлага мөн “бүх талын оновчтой оролцоог үргэлжлүүлэн үнэлж”, “санал болгож буй дэд төслүүдийн талаарх үндэслэлтэй санаа зовоосон асуудлууд, оролцогчдын зүгээс тавьсан асуултын талаар иж бүрэн Үнэлгээний судалгаа хэрэгжүүлэхэд Хүлээн авагчийг дэмжинэ”⁸ хэмээн дурджээ. Мөн зөвлөлдөх уулзалтууд, түгээлт болон үнэлгээний судалгааг зохих журмын дагуу хийх нь Банкны бодлого, журамд нийцэж байгаа болохыг энд нэмж оруулсан байна.⁹

Д. ОХУ, Монголд ажилласан томилолт

36. Хяналтын Хорооны дарга Ганзола Кастро дэ ла Мата, хорооны гишүүн Зэйнаб Эл Бакри болон үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Татьяна Тассони нар 2015 оны 5 дугаар сарын 3-9-ний өдрүүдэд ОХУ, Монгол Улсад томилолтоор ажилласан болно. Ажлын хэсэг ОХУ-д Байгаль нуурын өмнөд бүс нутаг болон БН Буриад Улсын нутаг дэвсгэр дэх Сэлэнгэ мөрний адаг орчмоор зочилж, Хүсэлт гаргагчид, тэдний төлөөлөл

⁷ Удирдлагын хариу: 29, 30

⁸ Удирдлагын хариу: 29, 30

⁹ Удирдлагын хариу: 30

болон бусад нөлөөлөлд өртөх орон нутгийн бүлгийн гишүүдтэй уулзсан юм. Улаан-Үд хотод багийнхан Байгалийн нөөцийн яамны албаны хүмүүс, Буриад улсын Байгалийн нөөцийн яам, Загас агнуурын холбооны агентлаг, болон Усны нөөцийн холбооны агентлагийн хүмүүстэй уулзлаа. Монгол Улсад Эрдэнэт хот болон Шүрэнгийн УЦС-ын үйл ажиллагаанд өртөж болзошгүй гол газраар зочилж, Хүсэлт гаргагчид, тэдний төлөөлөл болон бусад нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн бүлгийн гишүүдтэй уулзсан. Багийнхан Улаанбаатар хотод ДБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын удирдлага, ажлын хэсэг, Засгийн газрын байгууллагууд болон УУДБХОДТ-ийн ТУБ-ийн албаны хүмүүстэй уулзаж ярилцав.

37. Хороо дээр дурдсан хувь хүмүүс болон бүлгүүдээс өөрийн үзэл бодол, мэдээлэл, ойлголтын талаар тодорхой ойлголт өгөхийг хүссэн. Хорооны зүгээс хүмүүстэй уулзаж, тэдэнтэй үзэл бодлоо илэн далангүй солилцох боломж олгосонд Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын БН Буриад улсын Засгийн газарт талархлаа илэрхийлж байна. Мөн Хүсэлт гаргагчид, нөлөөлөлд өртсөн хүмүүс, Улаанбаатар хот дахь Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газрын ажилтнуудад цаг гарган, асуудлын талаар ярилцаж, холбогдох мэдээллээр хангасанд талархлаа илэрхийлье. Ялангуяа ОХУ болон Монгол Улс дахь Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газрын ажилтнуудад ложистикийн зохицуулалт хийж үнэлж баршгүй дэмжлэг үзүүлсэнд талархаж байна.

ОХУ-д ажилласан томилолтын үеэр хийсэн ажиглалтууд

38. Орос улсад хийсэн энэхүү томилолтын явцад хорооны ажлын хэсэг Шүрэнгийн УЦС-ын үйл ажиллагааны улмаас Сэлэнгэ мөрний ай сав, Байгаль нуурт үзүүлж болзошгүй нөлөөлөлд ихээр санаа зовниж буйгаа илэрхийлсэн нутгийн оршин суугчид, нийгмийн бүлгийн төлөөллүүд, болон орон нутгийн засаг захиргааны хүмүүс зэрэг хэд хэдэн Хүсэлт гаргагчидтай уулзсан. Гишүүд маш олон талын ноцтой асуудлуудыг сонсож, далан байгуулснаар Байгаль нуурын усны түвшин багасч, Сэлэнгэ мөрний урсгал өөрчлөгдөн ялангуяа зуны улиралд хүрээлэн буй орчин, айл өрхийн амьжиргаа, соёлын өв, болон орон нутгийн эдийн засагт учруулах хохирлын үр дүнгийн талаар санаа зовниж байгааг сонслоо.

39. Экологийн нөхцөл байдлын тухайд, Хүсэлт гаргагчид болон Оросын орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, Шүрэнгийн УЦС нь голын усны байгалийн эргэлтийг өөрчлөх, Сэлэнгэ мөрний жилийн усны урсац ба цутгаланг дахин хуваарилах зэргээр өөрчлөгдөхөд санаа зовниж байлаа. Тэдний үзэж байгаагаар, эдгээр өөрчлөлтүүд нь аль хэдийнэ эмзэг болсон Байгаль нуурын онцлог экосистемийг гэмтээхэд нөлөөлж, аливаа голын жилийн урсац түүний экологийн нэгдлийн нэг чухал баталгаа болдог ажээ. Урсацын дахин хуваарилалт нь загасны халдварт өвчин дэгдэх, Сэлэнгэ мөрний адгийн намгархаг газар доройтолд өртөх, нуурын эрэг орчим сүйдэх зэргээр их хэмжээний хортой нөлөө үзүүлж болно. Тэд мөн аливаа далан нь Байгаль нуурын биологийн төрөл зүйлийг хамгаалахад гол үүрэг гүйцэтгэж буй Сэлэнгэ мөрний адаг орчмын гүехэн хэсэгт зайлшгүй нөлөө үзүүлнэ гэдгийг нэмж тэмдэглэсэн байна. Эдгээр гүехэн устай хэсэг нь усны шүүлтүүрийн үүрэг гүйцэтгэдэг тул дэлхийд алдартай Байгаль нуурын усыг цэвэр тунгалаг болгохын зэрэгцээ, цөөн тоогоор тархсан болон ховордсон омуль зэрэг загасны үр төл өсч торних нөхцлийг бүрдүүлдэг байна.

40. Орос дахь Хүсэлт гаргагчид Шүрэнгийн УЦС-ын үйл ажиллагаа нь тэдний амьжиргаа болон орон нутгийн эдийн засагт хор хохирол учруулж болзошгүй талаар тайлбарлаж байв. Багийнхантай уулзсан загасчин хэлэхдээ далан нь гол, нуурын усны түвшинг багасгаснаар ялангуяа зуны улиралд загасчлахад, тэр дундаа омуль загас барихад их хүндрэлтэй болгох талаар санаа зовж байгаагаа илэрхийлж байв. Тэд, далан нь ундны хэрэгцээгээ хангадаг худаг аль хэдийнэ ширгэж эхэлсэн байдлыг улам бүр дордуулан, аялал жуулчлалын хувьд түгшүүртэй нөхцөл байдлыг бий болгоно гэдэгт итгэлтэй байлаа. Иргэд далангийн үйл ажиллагаанаас болж өвлийн цагт тосгон, тариан талбай болон бэлчээр усанд автуулж, голын голдрил аль хэдийнэ нарийсч байгаатай ижил үйл явдал болно гэдэгт итгэлтэй байна.

41. Соёлын өвд үзүүлэх нөлөөллийн хувьд, БН Буриад улсад христийн “Хуучны итгэгчид” хэмээх урсгалын дэлхийн хамгийн том бүлэг байдаг, тэд Сэлэнгэ мөрний ай саваар амьдарч, мөрөн, далайн ус нь тэдний амьдралын эх үүсвэр болдог байна. Тэдгээр хүмүүсийн үзэж байгаагаар Шүрэнгийн УЦС-ын бүтээн байгуулалт болон үйл ажиллагаа нь маш олон нийгмийн бүлгүүд орлогын эх үүсвэрээ алдсаны улмаас дүрвэх, бүлэг хоорондын харилцаа тасрах, тэдний амьдралын уламжлалт хэлбэрээ алдах зэргээр нөлөөлж соёл болон шашны өв аюулд өртөхөөс санаа зовж байна.

42. Оросын Хүсэлт гаргагчид УУДБХОДТ-ийн хүрээнд хийгдсэн үнэлгээний судалгааны өөр өөр шатан дахь зөвлөлдөх уулзалт болон оролцооны асуудалд санаа зовж байгаагаа илэрхийлж байв. Тэд төслийн баримт бичиг нь Орос хэлээр орчуулагдаагүй учраас Оросын талын оролцогчид үйл явцын талаар мэдээлэлгүй, мөн 3 дахь үе шатны Ажлын даалгаварын талаарх сүүлийн зөвлөлдөх уулзалтад тэднийг урьж оролцуулаагүй талаар гомдол гаргасан юм. Тэд Шүрэнгийн УЦС-ын талаар Англи хэл дээрх ТЭЗҮ-ний Ажлын даалгаварт саналаа хүргүүлсэн боловч нэгийг ч тусгаагүй гэдгийг баталж байлаа. Тэд УУДБХОДТ нь Монгол, Орос аль ч хэлээр иргэдийн санал хүсэлт хүлээж авах, шийдвэрлэх механизм байдаггүйг мөн тэмдэглэсэн билээ.

Монголд ажилласан томилолтын үеэр хийсэн ажиглалтууд

43. Монголд хийсэн томилолтын үеэр ажлын баг Шүрэнгийн УЦС-ын нөлөөлөлд автаж болзошгүй байгаа Сэлэнгэ мөрний эрэг дээрх чухал орчноо алдахаас санаа зовниж буй Монголын Зөгийн аж ахуй эрхлэгчдийн холбооны төлөөлөлтэй уулзлаа. Тэдний тухайд, энэхүү газар нутаг нь олон төрлийн цэцэгсээр баялаг бөгөөд Монголын Зөгийн аж ахуй эрхлэгчдийн томоохон хувийг орон нутгийн олон арван хүн бүрдүүлдэг байна. Тэд олон зүйлийн ховордсон, орон нутгийн шинжтэй ургамал устаж болзошгүй байгаад сэтгэл зовниж байгаагаа мөн илэрхийлж байв.

44. Хорооны гишүүд Шүрэнгийн УЦС-ын төслийн үйл ажиллагаанд өртөж болзошгүй газар нутагт зочлон нутгийн иргэдтэй уулзсан юм. Нутгийн иргэд энэхүү санал болгож буй төслийн улмаас нүүлгэн шилжүүлж магадгүй гэсэн цуу яриа сонссон гэдгээ тэмдэглэж байв. Тэд амь, амьжиргаанд нь нөлөөлж болзошгүй нөлөөлөлд санаа зовниж буйгаа илэрхийлээд, санал болгож буй төсөл болон нутгийн иргэдэд хэрхэн нөлөөлөх талаар ямар ч мэдээлэл аваагүй болохоо мэдэгдсэн.

45. Хорооны ажлын хэсгийн гишүүд Улаанбаатар хотод Сангийн яам, Эрчим хүчний яам, БОНХАЖЯ-ны мэргэжилтнүүд болон ТУБ-ийн ажилтнуудтай уулзав. Төрийн байгууллагын мэргэжилтнүүд Монгол орны эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдал, уул уурхайн салбарын хөгжлийн хэрэгцээнд Шүрэнгийн УЦС-ын гүйцэтгэх үүргийн талаарх байр сууриа хатуу илэрхийлж байлаа. Тэд түүнчлэн УУДБХОДТ-ийн тусламжтай гүйцэтгэж буй үнэлгээний үр дүнгээс хамаарч Шүрэнгийн УЦС-ийн төсөл үргэлжлэх эсэх эцсийн шийдвэр гарах болно гэдгийг мэдэгдсэн. Мөн ТЭЗҮ судалгаа болон БОННБҮ хийгдэж дууссан тохиолдолд төслийг хувийн хөрөнгө оруулалт эсвэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар санхүүжүүлж болно гэдгийг илэрхийлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газар төрөл бүрийн бие даасан сангуудаас санхүүжилт эрэлхийлж байгааг мэдэгдсэн юм.

46. ТУБ-ийн ажилтнууд нарийвчилсан бичиг баримтаа хорооны ажлын багтай хуваалцсан. Шүрэнгийн УЦС-ын БОННБҮ-ний Ажлын даалгаврын төслийн талаар 1 дүгээр сард хийсэн олон нийтийн зөвлөлдөх уулзалтын үеэр хүлээн авсан саналуудыг нэгтгэх явц одоогоор дуусаагүй болохыг тэд хорооны ажлын багт мэдээлсэн.

Техникийн нийцтэй байдал

47. Хүсэлтийн техникийн нийцтэй байдал нь 1999 оны Тодруулгын 9 хэсэгт заасан шалгуурын дагуу тодорхойлогдсон бөгөөд бусад хүчин зүйлсийн талаарх ажиглалт нь Хорооны зөвлөмжийг дэмжиж байна. Энэ утгаараа хороо Хүсэлт нь техникийн нийцтэй байдлын бүх зургаан шалгуурыг хангаж байгаад сэтгэл хангалуун байв:

- Шалгуур (а): “Нөлөөлөлд өртсөн тал нь зээлдэгчийн нутаг дэвсгэрт оршин суудаг, ижил бэрхшээл, ашиг сонирхолтой 2 буюу түүнээс дээш хүмүүсээс бүрдэнэ.” Хороо хүсэлт гаргагчдын бүрэлдэхүүнд УУДБХОДТ-ийн үйл ажиллагаанд өртөж болзошгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч буй нийгмийн бүлгийн гишүүд багтсан болохыг баталж байна. Хороо мөн ОХУ-ын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүсэлт гаргагчид нь сөрөг нөлөөнд өртөж болзошгүй гэдгийг нотолж байна. Тиймээс хороо энэ шалгуурыг хангасан гэж үзэж байна.
- Шалгуур (б): “Хүсэлт нь Банк өөрийн үйл ажиллагааны бодлого, журмаа ноцтой зөрчиж байгааг, эсвэл хүсэлт гаргагчид материалын сөрөг нөлөө үзүүлж байгааг нотлох ёстой.” Хүсэлт гаргагчид нь УУДБХОДТ-ийн хүрээнд үнэлгээний судалгаа нь санхүүжигдэж буй дэд төслүүд хэрэгжвэл, эрсдэлийн болон хэмжүүрийг багасгах шинжлэх ухааны үнэлгээ дутмаг, төслийн хувилбаруудад шинжилгээ хийгээгүй, хуримтлагдах болон хил дамнасан нөлөөллийн үнэлгээг багтаагаагүй болон дэд төслүүдийн сонголтын үйл явц нь хангалтгүй байсан зэрэг учир шалтгаануудын улмаас хохирол учруулж магадгүй гэж Хүсэлт гаргагчид нотолж байна. Хүсэлт гаргагчид иргэдийн аж амьдрал, соёлын өв цаашлаад тэдний амьдарч буй орчинд хүнд хохирол учруулж болзошгүй гэдэгт итгэлтэй байв. Хүсэлт гаргагчид дэд төслүүдийн нөлөөлөлд өртөж болзошгүй бүлгүүдэд зориулсан зөвлөлдөх уулзалт, мэдээлэл түгээх үйл ажиллагаанд зориулсан УУДБХОДТ-ийн санхүүжилт хангалтгүй байсан гэдгийг батлан хэлсэн. Хүсэлтэд эдгээр зөрчлүүд нь Банкны үйл ажиллагааны хэд хэдэн бодлого, журамд нийцэхгүй байгааг нотолсон байна. Тиймээс хороо энэ шалгуурыг хангасан гэж үзэж байна.

- Шалгуур (в): “Хүсэлт нь Удирдлагын анхааралд хүргэсэн асуудал нь Хүсэлт гаргагчийн бодлоор Удирдлага хангалттай хариулт өгөөгүй, эсвэл банкны бодлого, журмыг дагах алхам хийгээгүй болохыг батлах ёстой.” Хороо хүсэлт гаргагчид хүсэлт гаргах хүртэлх хугацаандаа уг асуудлын талаар олон удаа Банкны анхааралд хүргэж байсныг баталж байна. Тиймээс хороо энэ шалгуурыг хангасан гэж үзэж байна.
- Шалгуур (г): “Асуудал нь худалдан авах үйл ажиллагаатай холбогдох ёсгүй.” Хороо хүсэлт нь худалдан авах үйл ажиллагаатай холбогдоогүй тул шалгуурт нийцсэн гэж үзэж байна.
- Шалгуур (д): “Холбогдох зээл нь хаагдаагүй эсвэл ихэнх нь зарцуулагдаагүй байх.” Хүсэлт хүлээн авах үед төсөл 31 хувийг зарцуулсан байв. Төслийн хаагдах хугацаа нь 2016 оны 9 дүгээр сарын 30 юм. Тийм учраас энэ шалгуур шаардлага хангасан байна.
- Шалгуур (е): “Хороо тухайн асуудлын талаар өмнө нь дүгнэлт гаргаж байгаагүй, хэрвээ тийм бол, тухайн үед өмнөх хүсэлтэд мэдэгдээгүй шинэ баримт орсон эсвэл хүсэлт гаргах хүртэлх хугацаанд мэдэгдээгүй байсан талаар хүсэлтэд дурьдсаныг батлах.” Хороо хүсэлтэд хамаарах асуудлаар өмнө нь зөвлөмж гаргаж байгаагүй гэдгээ мэдэгдсэн тул шалгуурт нийцэж байна.

48. Хороо нь Хүсэлт гаргагчийн Хүсэлтэд дурьдагдсан томоохон цар хүрээтэй нотлогдохуйц баримтанд суурилсан техникийн нийцтэй байдлын нотолгоо, Хүсэлт гаргагчийн нэхэмжлэлийн дүгнэлтэнд хорооны үнэлгээг оруулаагүй болохыг тэмдэглэж байна.

Хорооны зүгээс хийсэн ажиглалт

49. Хорооны дүгнэлт нь хүсэлт, удирдлагын зүгээс өгсөн хариулт, нэмэлт нотлох баримт, Орос, Монголд хийсэн томилолтын явцад цуглуулсан баримт зэрэгт үндэслэсэн болно. Хорооны Үйл ажиллагааны журамд заасны дагуу Хороо нь зөвлөмж гаргахдаа хүсэлт болон төсөлд заасан хор хохирлын хооронд магадлал бүхий уялдаа холбоо байгаа эсэх, эдгээрт дурдсан хор хохирол болон Банкны зүгээс дүрэм, журмыг үл мөрдсөн байж болзошгүй байдал нь ноцтой шинж чанар агуулж байгаа эсэх, Удирдлага нь асуудалд зүй зохистой хандсан эсэх, эсвэл зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрч, засч залруулах арга хэмжээний талаар мэдэгдэл гаргах замаар хүсэлт гаргагчдын хөндөж тавьсан асуудлуудыг шийдвэрлэсэн эсэхийг анхаарч үздэг. Эдгээр асуудлыг доор авч үзлээ.

УУДБХОДТ-ийн үйл ажиллагаа, болзошгүй хохирлын талаарх мэдэгдэл хоорондын холбоо хамаарал

50. Хүсэлт нь Орхон Говь төсөл болон Шүрэнгийн УЦС-ын Үнэлгээний судалгаа ба зөвлөлдөх уулзалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй асуудлыг хөндөн гаргасан байна. Хүсэлт гаргагчдын гарган тавьж байгаагаар УУДБХОДТ-ийн үйл ажиллагааны хэрэгжилт тэр дундаа Орхон Говь төсөл, Шүрэнгийн УЦС төслийн Үнэлгээний судалгааны явцад Банкны удирдлага холбогдох үйл ажиллагааны бодлого, журмыг дагаж мөрдөөгүйгээс урган гарсан гэж үзжээ.

51. Удирдлага өөрийн хариундаа Хүсэлт гаргагчийн нэхэмжлэлд дурьдсан хохирол нь төслийг дэмжих үнэлгээний судалгааны ажлаас илүүтэйгээр УУДБХОДТ-ийн хүрээнд хийгдсэн дэд төслүүдийн барилгын бүтээн байгуулалт болон үйл ажиллагаанаас бий болох асуудалд илүү холбогдох тул Хүсэлтийг “нягтлах шаардлагагүй” гэж дурдсан байна. Удирдлагаас Банк нь дэд төслүүдийн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хамааралгүй бөгөөд санхүүжүүлэх үүрэг хүлээгээгүй болохоо тэмдэглэж байна. Хүсэлтэнд дурдсан хохирол нь үнэлгээний судалгаанаас шалтгаалахгүй бөгөөд “Монгол Улсын Засгийн газраас санал болгож буй дэд төслүүдийг үргэлжлүүлэх эсэх шийдвэр гаргахад үйлчлэхгүй.” Үнэлгээний судалгааг санхүүжүүлсэн нь банкны бодлого, журмыг хэрхэн яаж зөрчиж, улмаар Хорооны шийдвэрт заасанчлан бодит эсвэл боломжит хор хохирол учрахад хүргэснийг олж харахгүй байна гэж Удирдлага мэдэгдэв.”¹⁰

52. Хороо үнэлгээний судалгаа, хохирлын шалтгаан хоорондын тохиолдлын уялдаа холбоо байх боломжийн тухай асуудлыг магадласан юм. Хороо нь Банк дэд төслүүдийг санхүүжүүлэхгүй, тийм үүрэг хүлээгээгүй бөгөөд УУДБХОДТ нь эдгээр дэд төслийн зөвхөн үнэлгээний судалгаанд дэмжлэг үзүүлж байгаагаа илэрхийлсэн удирдлагын байр суурийг ойлгон, баталгаажуулж байна.

53. УУДБХОДТ-ийн хүрээнд санхүүжигдсэн Орхон-Говь, Шүрэнгийн УЦС төслийн үнэлгээний судалгаануудын тухайд бол хэрэвзээ Банк эдгээр дэд төслийг санхүүжүүлж байсан бол авч хэрэгжүүлэх л байсан төслийн ердийн бэлтгэл үйл ажиллагаатай ижил байна гэж Хорооны зүгээс үзэж байна. Түүнчлэн Хороо нь хэрэв үнэлгээний судалгаагаар төслийг үргэлжлүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гарвал Монгол Улсын Засгийн газар нэмэлт ТЭЗҮ, нөлөөллийн судалгаа хийхийг шаардалгүйгээр санхүүжилтийн сүүлийн шатанд шилжинэ гэж Засгийн газрын мэргэжилтнүүдээс сонссон. **Тиймээс, Хороо нь УУДБХОДТ-ийн 3 дахь үе шатыг хэрэгжүүлэхдээ Банкнаас хэрэгжүүлдэг стандарт Хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэлийн үе шаттай адил, хариуцлагын ижил стандарттай байх ёстой гэж үзэж байна.** Энэ байр суурийг доор нарийн тайлбарлана.

54. Хороо УУДБХОДТ-өөр санхүүжсэн үнэлгээнүүд нь салбарын өргөн асуудал, үндэсний стратеги, эсвэл өргөн цар хүрээтэй үнэлгээний ажил биш гэдгийг онцолж байна. Харин тэдгээр нь хороо албаны хүмүүстэй уулзахдаа мэдэгдэж байсанчлан, тухайлсан дэд төслүүдийн техник дизайныг гаргах төслийн ТЭЗҮ, БОНҮ бөгөөд Монгол Улсын Засгийн газар бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх эсэхээ шийдвэрлэх юм. Шүрэнгийн УЦС-ын Ажлын даалгаврын талаарх Хорооны дүгнэлтийн адилаар, БОННБҮ нь дэд төслүүдийн хүрээнд боловсруулах байгаль орчин нийгмийн үнэлгээ, нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний үндсэн загвар болж болно. Түүнчлэн, байгаль орчин, нийгмийн төлөвлөгөө нь УУДБХОДТ-ийн БОНУБ-д багтсан удирдамж болон ерөнхий бүтцийг дагах юм.

55. Энэ агуулгын хувьд, Хороо УУДБХОДТ-ийн БОНУБ-д дурьдсанчлан “дагалдан хийх ТЭЗҮ судалгаа, ТХХТ-ийн хэлэлцээр, тодорхойлогдсон төслүүдийн ирээдүйн хэрэгжилт нь БОНУБ - гийн асуудал болох”¹¹ ба “Сангийн яамны харьяа ТУБ нь БОНУБ

¹⁰ Удирдлагын хариу 15-р хуудас

¹¹ БОНУХ, х

хэрэгжүүлэх бүрэн хариуцлага хүлээн (1-р хавсралт, БОННБҮ-ний Ажлын даалгаврын 5-р хавсралт болон бусад хавсралт) БОНУБ-ийн дагуу тэднийг хэрэгжүүлэх ба баримт бичгийн аюулгүй байдлын бэлтгэлийн протоколыг багтаасан гэрээний баримт бичгийг нэгтгэсэн байна.” гэж заасан болохыг тэмдэглэж байна.¹²

56. Тиймээс зөвлөлдөх уулзалтын үе шат болон үнэлгээний судалгаа (ялангуяа БОННБҮ)ны аливаа дутагдлыг засахгүй бол, цаашдаа Орхон говь төсөл, Шүрэнгийн УЦС төслийн дизайныг боловсруулахад алдаа гарахад хүргэж, эдгээр алдаа дутагдлыг залруулахад Монгол Улсын Засгийн газраас бие даасан дараагийн алхам хэрэгжүүлэх шаардлагатай болно гэж Хороо үзэж байна. **Үүнээс харахад дэд төслүүдийн хэрэгжилтээс үүдсэн аливаа болзошгүй хохирол нь зөвлөлдөх үе шат, үнэлгээний судалгааны талаарх Банкны бодлого, журмыг биелүүлээгүйтэй илэрхий холбогдож болох юм.**

57. Хорооны бүрэн эрхийн хүрээнд үнэлгээний судалгаа багтах бөгөөд, дээрх судалгаанууд нь өргөн хүрээг хамарсан эсвэл ерөнхий судалгааг багтаасан эсэхээс илүүтэй дэд төслүүдийг бэлтгэхдээ Хүсэлт гаргагчдын санаа зовнисон асуудлаар шаардлагатай алхамуудыг хангалттай авсан байдалд үндэслэн шинжилж болно гэж Хороо дүгнэж байна.

Хор хөнөөл, хууль дүрмийн үл мөрдөлтийг ноцтой хэмжээнд аваачих хязгаар

58. *Чухал ач холбогдол бүхий байгалийн амьдрах орчинд учирч болзошгүй хор хөнөөл.* Хороо томилолтын хугацаанд олж сонссон ихэнх санаа зовоосон асуудал нь гол мөрний урсгал дагуу, адаг хэсэгт нь учрах нөлөөлөлтэй шууд болон шууд бусаар холбогдож байгааг тэмдэглэж байна. Тэдгээр нөлөөлөл нь Сэлэнгэ мөрний урсгалын өөрчлөлт, Орхон говь, Шүрэнгийн УЦС төслийн үйл ажиллагаа, дэд бүтцийн бүтээн байгуулалтын улмаас үүсэн бий болж, улмаар ОХУ-ын нутаг дахь Байгаль нуур, Сэлэнгэ мөрний адаг орчмын экологи, гидрологид нөлөөлж болзошгүй юм. Төсөл нь байгалийн өвөрмөц, юугаар ч орлуулшгүй амьдрах орчинд нөхөж баршгүй аюул занал учруулах тул УУДБХОДТ нь Сэлэнгэ мөрний сав газарт барих даланг судлавал зохих боломж гэж тодорхойлох ёсгүй байсан юм гэж хүсэлт гаргагчид үзэж байна. Тэд дэд төслүүдийг сонгон шалгаруулах явцын талаар ахин дахин асууж, дэд төслүүдийг анхлан тодорхойлох, үйл явцын дараа дараагийн үе шатанд үнэн бодит үнэлгээ хийх шударга механизм байгаагүй гэж мэдэгджээ.

59. Сэлэнгэ мөрний адаг орчмын газар нь байгалийн чухал ач холбогдолтой амьдрах орчин бөгөөд ба 1994 оноос хойш “Олон улсын намгархаг газар, ялангуяа усны шувуудын амьдрах орчны тухай конвенциор” (Рамсарын конвенц) олон улсын хэмжээний ач холбогдолтой намгархаг газар гэж хүлээн зөвшөөрөгдсөөр ирсэн байдаг. Рамсарын конвенцид дурьдахдаа “энэхүү газар нутагт Байгаль нуурын гүехэн устай хэсэг, голын эрэг болон урсгал багтана. Ургамлын хувьд зэгс, нугын хадлангийн өвс, бургаснаас бүрдэнэ. Энэхүү газар нутаг нь өвөрмөц намгархаг газрын жишээ бөгөөд амьтан, ургамлын ховордсон, нутагшмал төрөл зүйлийг олноор нь дэмждэг” гэсэн байна.

60. Сэлэнгэ мөрний адаг орчмын газар нь “биологийн төрөл зүйл, хүний нийгмийн аль алиных нь хувьд маш чухал нөөц болж өгдөг. Олон төрөл зүйлийн нүүдлийн шувууд энд

¹² БОНУХ, х 17

олноороо ирж, үржиж, өдөө хаядаг. Нийт өсч үрждэг галуу, нугас, хунгийн тоо толгой 20 мянгаас 138 мянгад хүрдэг байна. Нийтдээ 5 сая хүртэлх тооны нүүдлийн шувууд мөрний бэлчирийг намар дайрч өнгөрдөг бөгөөд 7300-18300 шувууд өнждөг байна.” Рамсарын конвенцид мөн “өвс хадах, мал бэлчээрлүүлэх, арилжааны болон спортын загасчлал хийх, үхэр халиунд урхи тавих, усны шувуудыг агнах, наадам зугаалга хийх зэрэг хүний үйл ажиллагаа, гол мөрний зохицуулалтын улмаас гидрологийн дэглэм өөрчлөгдөж, нуурын усны түвшин нэмэгдсэн (Байгаль нуур) нь бэлчирийн экосистемд тулгарч буй голлох аюул юм” хэмээн онцолсон байна.

61. Сэлэнгэ мөрний адаг орчмын газар нь Байгаль нуурын эрэгт орших Дэлхийн өвд бүртгэгдсэн газар нутаг юм. ЮНЕСКО-д бүртгэгдсэнээр “3,15 сая га талбай нутаг дэвсгэртэй Байгаль нуур нь дэлхийн хамгийн өндөр настай (25 сая жил), хамгийн гүнзгий (1,700 м) нуур юм. Дэлхийн хөлдөөгүй цэвэр усны 20%-ийг агуулж байдаг байна. “Оросын Галапагос” хэмээн нэрлэгдсэн энэхүү далайн насжилт болон тусгаарагдсан байдал нь дэлхийн хамгийн баян, хамгийн ер бусын цэнгэг усны ургамал, амьтдыг бий болгосон бөгөөд энэ нь эволюцын шинжлэх ухаанд онцгой үнэ цэнэтэй байдаг.

62. Байгаль нуур болон Сэлэнгэ мөрний адаг хавийн экологийн эрүүл мэнд нь цутгах болон гадагш урсах усны эргэлт болон гидрологийн урсгалаас шууд хамаарна. Цутгал нь ерөнхийдөө Сэлэнгэ мөрөн бөгөөд Оросын Ангар мөрнөөс эх авдаг байна. 2008 онд Солонгос улсын Байгаль орчны хүрээлэнгээс хийсэн “Сэлэнгэ мөрний сав газрын усны цогц удирдлагын загвар”¹³ хэмээх иж бүрэн судалгаанд Сэлэнгэ мөрөн Байгаль нуурын нийт усны 50 хувийг цутгаж, нийлүүлдэг бөгөөд Орос, Монголын хил орчимд энэ тоо 23 хувь болж, бусдыг нь Оросын нутгаас нийлсэн олон цутгалан бүрдүүлдэг гэдгийг дурдсан байна. Сэлэнгэ мөрний гидрологийн дэглэмээр Монголын хилээс Байгаль нуур хүртэлх газар нутгийн ус цутгалтын хэмжээ нь бага устай өвлийн үед 30 м³/сек, харин үерлэсэн зуны үед 7,620 м³/сек-ийн хооронд хэлбэлзэж байна. Байгаль нуураас Ангар мөрөн рүү урсаж буй доод урсацад хэд хэдэн эрчим хүч үйлдвэрлэх усан цахилгаан станц байгуулах зэргээр Оросын эрх баригчид зохицуулан ашиглаж байна.

63. Сэлэнгэ мөрний урсгал Байгаль нуур болон Сэлэнгэ мөрний адаг орчмын газрын эрүүл мэндэд чухал ач холбогдолтой бөгөөд Орхон говь, Шүрэнгийн УЦС төслийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалт нь эдгээр урсгалыг өөрчилж болзошгүй гэдгийг харгалзан үзсэний үндсэн дээр, **санал болгож буй дэд төслүүдийн зүй бус хэрэгжилтийн улмаас үүсч болзошгүй хор нөлөөлөл нь үнэхээр ноцтой шинж чанартай байна гэж Хороо дүгнэж байна.**

64. *Зөвлөлдөх уулзалт ба мэдээллийг түгээх.* ОХУ болон Монгол Улсад хийсэн томилолтын хугацаанд Хорооны ажлын хэсэг Орхон Говь төсөл болон Шүрэнгийн УЦС-ын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн байгууллага, нийгмийн бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагуудтай хийх зөвлөлдөх уулзалт дутмаг байгаа талаар байнга сонсож байв. Ярилцлага өгч буй хүмүүс дэд төслүүдийн тодорхойлолтын талаар болон эхний шатны үнэлгээнд оролцогчын хувиар оролцож чадаагүйдээ харамсаж байв. Далангийн бүтээн байгуулалтын улмаас Орос улсын нутаг дэвсгэрт ноцтой, томоохон сөрөг

¹³ http://www.unep.ch/etb/areas/pdf/NISD%20partnership%20project_Phase1%20Report%5B1%5D.pdf

нөлөөлөл үүсч болзошгүй байхад баримт бичгүүдийг орос хэл дээр орчуулж гаргаагүй хэмээн иргэний нийгмийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн эрх барих байгууллагын төлөөлөгчид Хороонд удаа дараа гомдол мэдүүлж байв. Түүнчлэн 2015 оны 1 дүгээр сард Шүрэнгийн УЦСТ-ийн БОННБҮ-ний ажлын даалгаврын талаар хийсэн зөвлөлдөх уулзалтад Оросын иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагуудын төлөөллийг урьж оролцуулаагүй талаар дурдаж байв. Тэд Оросын талыг төлөөлж оролцсон ганц хүн нь хэдий мэдлэг боловсрол сайтай ч, нөлөөлөлд өртөж буй нийгмийн бүлгүүдийн үзэл бодлыг хангалттай гаргаж чадаагүй гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлж байв.

65. Дээрх хоёр оронд, нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд болон Сэлэнгэ мөрний адаг, Байгаль нуурын оршиж буй Буриад улсын орон нутгийн эрх баригчдын мэдэгдэж байгаагаар үнэлгээний судалгааны талаарх мэдээлэл бараг байхгүй, тэр дундаа урьдчилсан ТЭЗҮ судалгааг олон нийтэд огт танилцуулаагүй байна. Үүнийг ч Удирдлагын хариултанд хүлээн зөвшөөрсөн байна. Хүсэлт гаргагчид өөрсдөө үзэж танилцсан БОННБҮ-ний ажлын даалгавар зэрэг баримт бичигт өөрсдийн санал бодлоо тодорхой илэрхийлж явуулсан боловч тэдний санаанууд дэмжигдээгүй талаар мөн санал бодлоо нэмсэн. Тэд санал хүлээн авах арга замын талаар тодруулж байв. Монголд, Хорооны ажлын багийнхан Шүрэнгийн УЦС-ын үйл ажиллагаанаас шалтгаалан усанд автаж болзошгүй бүлгийнхэнтэй уулзсан ба тэд далангийн талаарх төлөвлөгөө, тэдний амьдрал, амьжиргаанд нөлөөлж болзошгүй төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэлгүй байгаа талаараа хэлж байв. Хороо ТУБ-ийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаасаа Сангалтай багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх эсэхийг ТЭЗҮ болон байгаль орчин, нийгмийн судалгааны техникийн эцсийн нөхцөлөөс хамаарч шийдэх юм байна гэж ойлгож байна. Зөвлөлдөх уулзалт болон бэлтгэл ажлын талаарх ямар нэгэн мэдээлэл тэдэнд болон тэдний төлөөлөлд хүрээгүй байв.

66. *Банкны бодлого, журамд нийцүүлэх асуудлууд.* Байгаль орчны болон нийгмийн судалгааг нарийвчлан явуулах явдлыг хангах, төслийн болзошгүй нөлөөллөөс зайлсхийх эсвэл бууруулах зохих арга хэмжээг тодорхойлох зарчим, заалтууд Банкны хамгааллын бодлогод багтсан байдаг гэдгийг Хороо тэмдэглэж байна. Бодлого нь төсөлд оролцогч талуудын оролцоо, хэлэлцүүлгийг шаардсан хатуу зүйл заалтуудыг агуулсан байна. Ялангуяа хүсэлт гаргагчдын илэрхийлсэн асуудлууд нь Байгаль орчны үнэлгээ (ҮАБ/БЖ 4.01) болон Байгалийн амьдрах орчны (ҮАБ/БЖ 4.04) талаарх бодлогод хамаарах юм. Байгаль орчны үнэлгээний бодлогод Банкнаас санхүүжүүлсэн төсөл, дэд төслүүд багтах бөгөөд дэд төслийн байгаль орчны үнэлгээг ҮАБ 4.01-т заасан шаардлагын дагуу хийх ёстой гэж тусгажээ. Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх зөвлөлдөх уулзалтыг нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, орон нутгийн төрийн бус байгууллагуудтай (ТББ) заасан хугацаанд нь, үр дүнтэй зохион байгуулах, эдгээр хүмүүст ойлгомжтой хэлээр, хүртээмжтэй байдлаар явуулдаг байхыг уг бодлогод маш тодорхой тусгасан байдаг.

67. Дэлхийн Банкны “Байгалийн амьдрах орчны талаарх бодлого”-д дурьдсанаар Банк нь “*хэрэгжүүлж болохуйц өөр зохистой хувилбар байхгүй бол байгалийн амьдрах орчинд томоохон өөрчлөлт оруулах төслийг дэмжихгүй [...] Хэрэв байгаль орчны үнэлгээнд уг төсөл нь байгаль орчныг их хэмжээгээр хувиргаж эсвэл доройтуулна гэж заасан байвал төсөл нь эдгээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг багтааж, үүнийг нь Банкны хүлээн зөвшөөрсөн байх ёстой [...] Байгалийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй*

төслийг дэмжих эсэхээ шийдэхдээ Банк зээлдэгчийн байгаль хамгаалах, хор хөнөөлийг бууруулах зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадварыг харгалзан үзнэ.” ҮАБ 4.04 нь байгалийн амьдрах орчинд нөлөөлөх төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх, тэднийг татан оролцуулах шаардлагын талаар маш тодорхой тусгасан байдаг бөгөөд нутгийн иргэд, орон нутгийн төрийн бус байгууллагуудын үзэл бодол, эрх, үүргийг анхаарч үзэх, ийм төслүүдийн төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд ард иргэдийг татан оролцуулах ёстой гэж заажээ.

ЮНЕСКО-ийн Дэлхий өвийн хөтөлбөрийн томилолтын ажлын тайлан

68. Дэлхийн өвийн хороо 2014 онд Доха хотноо болсон 38 дахь удаагийн хуралдааны үеэр Монгол Улсын Засгийн газар “Сэлэнгэ болон Орхон голын даланг байгуулахыг судалж үзсээр байгаа” гэж тэмдэглэжээ. Тиймээс “эдгээр төслөөс ХТНҮЦ (Хүн төрөлхтний нийтлэг үнэ цэнэ)-д учирч болзошгүй нөлөөлөл, тэр дундаа хуримтлагдах нөлөөллийг зохих ёсоор үнэлэхээс нааш эдгээр голд ямар ч далан барихгүй” байхыг Монгол Улсаас хүсэмжилсэн байна. Дэлхийн өвийн хөтөлбөр Дэлхийн өвийн хорооны хүсэлтээр 2015 оны 4 дүгээр сард “далангийн төслүүдийн цар хүрээ, хэмжээ болон төлөвийг хянан үзэж, эдгээр төслөөс Байгаль нуурт үзүүлж болзошгүй нөлөөллийн талаарх хэлэлцүүлгийг төлөвлөлтийн эхэн үед явуулах” зорилгоор судалгааны ажил явуулсан.¹⁴ 4 дүгээр сард хийсэн томилолт энэхүү хянан шалгуулах хүсэлтэд багтсан асуудлуудтай төстэй асуудлуудыг хамарсан тул Олон улсын байгаль хамгаалах холбоо (ОУБХХ)-нд байрладаг Дэлхийн өвийн хөтөлбөрийн ажилтнуудтай хэлэлцүүлэг хийсний дараа Хороо хянан шалгах шаардлагатай эсэх талаар зөвлөмж гаргахаасаа өмнө ДӨХ-ийн тайлантай танилцах нь нэн чухал гэж үзээд, дээр дурдсанчлан энэхүү тайлан, зөвлөмжийг өргөн барихыг хойшлуулсан юм.

69. Томиллолын ажлын үр дүнд ДӨХ-ийн тайланд¹⁵ биологийн төрөл зүйл болон экологийн үйл явц гэх мэт Байгаль нуурын бүрэн бүтэн байдалд “төслүүдийн үйл ажиллагааны улмаас учирч болзошгүй нөлөөлөлд тодорхой үнэлгээ хийх” ажлыг багтаах, Шүрэнгийн УЦС, ОГТ болон Сэлэнгэ мөрөн дээр барих гэж буй гуравдахь усан цахилгаан станцын төслийн үйл ажиллагааны улмаас учирч болзошгүй хуримтлагдах нөлөөллийг үнэлэх зорилгоор Шүрэнгийн УЦС болон ОГТ-ийн БОННБҮ-ний ажлын даалгаврыг дахин хянаж үзэхийг уриалсан. Уг тайланд Байгаль нуурын усны менежментийн чиглэлээрх хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн бэхжүүлж, Байгаль нуурт нөлөөлөл үзүүлж болзошгүй усан цахилгаан станц болон бусад төсөлд Байгаль орчны стратегийн үнэлгээг хамтран боловсруулдаг болохыг Монгол Улс болон ОХУ-ыг зөвлөсөн байна.

Удирдлагаас авах арга хэмжээ

70. Хяналтын хороо нь УУДБХОТ төслийн хүрээнд хийгдэх Үнэлгээний судалгаанууд эцэслэгдээгүй, ялангуяа хүсэлтэд дурдсан байгаль орчин, нийгмийн асуудлуудыг хамрах ТЭЗҮ болон БОННБҮ-үүд нь эхлээгүй байгааг ойлгож байна. Иймээс Хяналтын хороо нь “Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн талаарх үндэслэлтэй асуултууд бүхий

¹⁴ (WHC-14/38.COM/16 Доха, 2014 оны 7-р сарын 7, дараахаас үзэх боломжтой <http://whc.unesco.org/archive/2014/whc14-38com-16en.pdf> хамгийн сүүлд, 2015 оны 6-р сарын 15-нд өөрчлөлт орсон

¹⁵ <http://whc.unesco.org/en/documents/137186>

асуудлуудыг дэвшүүлсэнд хүсэлт гаргагчдад талархаж байна”, мөн “ОР4.01-д заасны дагуу эдгээр асуудлыг зөвхөн иж бүрэн, системтэй байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийх замаар шийдвэрлэж, хариулах боломжтой юм” гэсэн Удирдлагын мэдэгдлийг тэмдэглэж байна. “Хүсэлт гаргагчдын үндэслэлтэй асуудлуудыг эдгээр үнэлгээний судалгаанд багтааж, хянан үзэх болно” гэж Удирдлагын зүгээс нэмж дурдлаа.”¹⁶

71. Шүрэнгийн УЦС-ын БОННБҮ-ний ажлын даалгаварын урьдчилсан хувилбарт “Банкны үйл ажиллагааны бодлого 4.01 болон байгаль орчин, нийгмийн хамгааллын талаарх бусад холбогдох бодлогод заасан шаардлагыг хангаж, ... Олон нийттэй зөвлөлдөх, зохион байгуулалт сайтай хөтөлбөрөөр дэмжих”-ийг шаардаж буйг Хорооны зүгээс онцолж байна. Ажлын даалгаврын төсөлд далан болон голын усны байгалийн урсацын хоорондын харьцаа, Шүрэнгийн УЦС-аас ЮНЕСКО-ийн Дэлхийн өв болох Байгаль нуур, Рамсарын конвенцод орсон Сэлэнгэ мөрний адаг газарт хөрс шороо зөөвөрлөгдөн тунахаас үүдэх нөлөөллийг үнэлэх, мөн “Сэлэнгэ голд дараагийн 20 жилд төлөвлөсөн бүхий л усан болон усны эрчим хүчний дэд бүтцүүд болон дор хаяж Сэлэнгэ мөрний адаг газар болон Байгаль нуур хүртэлх газар нутгийг хамруулсан” хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх гэх мэт бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгасан юм. Түүнчлэн энэхүү ажлын даалгаврын төсөлд “олон улсын нэр хүнд бүхий усны эрчим хүчний салбарын техник, байгаль орчин болон нийгмийн чиглэлээрх олон улсын мэргэжилтнүүдээс бүрдсэн, ТЭЗҮ болон БОННБҮ-ний үр дүнг хянаж үзэх Шинжээчдийн багийг байгуулах шаардлагатай гэж үзсэн байна.

72. Зөвлөлдөх уулзалтын хувьд Удирдлага нь “БОННБҮ-ний зөвлөхүүдийг сонгон шалгаруулж, ажилд авсны дараа төслийн нөлөөлөлд өртөх оролцогч талуудтай дэлгэрэнгүй зөвлөлдөх уулзалт хийнэ” хэмээн мэдэгдэж, ажлын даалгаврын урьдчилсан хувилбарт голын урсгалын дагуух доод хэсэгт амьдардаг, нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэдтэй зөвлөлдөх зорилгоор төслийн нөлөөллийн бүсийг тогтоохдоо оролцогч талуудын байршлын зураглалыг гаргана гэж тусгажээ. Энэ хүрээнд Хяналтын хороо томилгоот ажлынхаа үеэр ОХУ-д оршин суугаа хүсэлт гаргагчид Шүрэнгийн УЦС-ын БОННБҮ-ийн ажлын даалгаврын талаар зөвлөлдөх уулзалтанд оролцох боломжгүй байсан бөгөөд одоог хүртэл төслийн баримт бичгүүдийг өөрийн хэл дээр уншиж, танилцаагүй байгааг онцолсон юм. Шүрэнгийн УЦС-ын БОННБҮ-ний ажлын даалгаврын урьдчилсан хувилбар орос хэл дээр орчуулагдсан ч олон нийтэд хараахан ил болгоогүй байгаа гэж Хороо ойлгож байна. Эдгээр оролцогч талтай үр дүнтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулахад тавигдах урьдач нөхцөл бол баримт бичгүүдийг орчуулах явдал юм. Мөн Байгаль орчны үнэлгээний тухай ҮАБ 4.01-д баримт бичгүүдийг орчуулах шаардлагыг тавьсан байдаг гэж Хороо тэмдэглэж байна. Хороо төслийн удирдлагын багтай уулзаж, БОННБҮ-ний ажлын даалгаврын талаар хүсэлт гаргагчдаас ирүүлсэн санал хүсэлтийг матриц хүснэгт хэлбэрээр нэгтгэсэн бөгөөд шинэ ажлын даалгаварт тусгах болно гэсэн ойлголтыг авсан.

Хорооны зөвлөмж ба дүгнэлт

73. Хорооны ажлын багтай уулзах үеэр Монгол Улсын Засгийн газрын албан тушаалтнууд Шүрэнгийн УЦС болон Орхон Говь төсөл нь тус улсыг тогтвортой, цэвэр

¹⁶ Удирдлагын хариу: 30

эрчим хүчний эх үүсвэр, усны хангамжаар найдвартай хангахад чухал ач холбогдолтой бөгөөд Монгол орон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхдээ нүүрсний хэрэглээнээс ихээхэн хамааралтай байгаа зэрэг бэрхшээлтэй асуудлын талаар тууштай хэлж ярьж байв. Мөн Хороо үндэсний уул уурхайн баялгийн нөөцийг олборлох эрчим хүчний эх үүсвэрийн чухал хэрэгцээ, энэ нөөц нь улс орны эдийн засагт асар том, эерэг нөлөө үзүүлнэ гэдгийг мэдэж байна.

74. Шүрэнгийн УЦС болон Орхон Говь төслийг УУДБХОДТ-ийн хүрээнд судлагдах төслөөр тодорхойлоход хүргэсэн үйл явц, Сэлэнгэ мөрний сав газарт далан барих ёсгүй гэсэн байр суурь, өнөөг хүртэл зөвлөлдөх уулзалтуудыг Орос улсад орос хэлээр явуулаагүй зэрэг хүсэлт гаргагчдын зүгээс хөндсөн асуудлуудыг Хороо тэмдэглэж байна. Түүнчлэн дэд төслүүдийг сонгохдоо эрчим хүчний бусад эх үүсвэрийг судлах эх үүсвэр болсон Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд (Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2012-2013 онд буюу УУДБХОДТ эхлэхээс өмнө хэрэгжиж дууссан) үндэслэсэн тухай дурдсан Удирдлагын мэдэгдлийг Хороо тэмдэглэж байна. Санал болгож буй Шүрэнгийн УЦС-ын шинжилгээ, урьдчилсан болон жинхэнэ ТЭЗҮ боловсруулах үед нөхцөл байдлын хувилбаруудыг харьцуулан авч үзэх талаар Удирдлага нэмж тэмдэглэлээ.

75. Үйл ажиллагааны журмын дагуу Хороо хүсэлт болон төсөлд дурдагдсан болзошгүй хор хөнөөлийн хооронд үнэмшилтэй уялдаа холбоо байгааг тогтоосон бөгөөд болзошгүй хор уршиг нь ноцтой шинж чанартай байна. Банкны хамгааллын бодлогод заасны дагуу нөлөөллийг нарийвчлан шинжилж, бууруулах арга хэмжээг тодорхойлох нь Хүсэлт гаргагчдын эмээж буй хор хохирлыг учруулахгүй байх, хамгааллын бодлогод тавигдаг стандартуудыг хангахын тулд эдгээр эрсдэлийг зохих ёсоор бууруулахад нэн чухал юм.

76. Хороо Засгийн газрын албан тушаалтнууд болон Банкны ажилтнуудтай хийсэн уулзалтын үеэр байгаль орчин, нийгмийн талаас нь авч үзвэл дэд төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг хараахан тодорхойлоогүй байгааг тэмдэглэж, Банк гагцхүү үнэлгээний судалгааны эцсийн үр дүнд үндэслэн зөвлөмжөө гаргах болно гэдгийг тэмдэглэж байна. Энэ талаар Монгол Улсын Засгийн газар дэд төслүүдийг үргэлжлүүлэх эсэх асуудалд Банкны зөвлөгөөг дагахаар төлөвлөж байгааг онцлон тэмдэглэжээ.

77. Өмнөх хэсэгт тэмдэглэсэнчлэн хүсэлт гаргагчдын зүгээс ТЭЗҮ болон БОННБҮ-ний үйл явцад гаргаж тавьсан асуудлыг шийдвэрлэх талаарх Удирдлагын үүрэг амлалт нь ард иргэд болон байгаль орчинд учирч болох засч болшгүй хор хөнөөлөөс зайлсхийхэд асар чухал үүрэг гүйцэтгэнэ гэж Хороо тэмдэглэж байна. Хороо амин чухал усан орчныг дундаа хуваалцдаг, үүнээс үүдэн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь эдгээр улс оронд тэгш, жигд бус байх магадлалтай нөхцөлд хил дамнасан хамтын ажиллагаа нэн чухал байх тул Монгол, Орос улсад үр дүнтэй хэлэлцүүлэг зохион байгуулах хэрэгтэй болохыг онцолж байна.

78. Эцэст нь дүгнэхэд, Хороо дээр дурьдсан болзошгүй хор хөнөөл, бодлого баримтлах асуудалд ач холбогдол өгч, ажлын даалгаврын бэлтгэл ажлын үлдсэн үе шат болон Шүрэнгийн УЦС болон Орхон Говь төслийн ТЭЗҮ ба БОННБҮ-ний судалгааны хэрэгжилтийн үед хүсэлт гаргагчдын тавьсан асуудалд нарийвчилсан шинжилгээ хийх талаар гаргасан Удирдлагын мэдэгдэл, үүрэг даалгаврыг онцолж байна. Хороо төслийн

хэрэгжилтийн дараагийн шатанд хүсэлт гаргагчдын тавьсан асуудалд анхаарал хандуулах асар их боломж олгож байгаа бөгөөд бүх оролцогч талыг хамруулсан ач холбогдол бүхий хэлэлцүүлгийг Оросын нутагт мөн адил зохион байгуулах зэрэг шаардлагатай залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар авч үзсэн юм.

79. Тиймээс Хороо Банкны үйл ажиллагаанд хяналт тавих эсэх талаар зөвлөмж гаргахаа хойшлуулсан болно. Хороо энэхүү Зөвлөмжийг тухайн үеийн хэлэлцүүлгийн үйл явцын чанарын нөхцөл байдал болон, ТЭЗҮ ба БОННБҮ-ний судалгааны үйл явц, цар хэмжээ, хамрах хүрээ зэргийг үнэлсний дараа нэг жилийн хугацаанд гаргана.

Хавсралт II

Монгол улс: “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” (P118109) болон “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл – Нэмэлт санхүүжилт” (P145439) төслийн талаар

Удирдлагаас Хяналтын хороонд ирүүлсэн шинэчлэгдсэн мэдээний тэмдэглэл

**МОНГОЛ УЛС: УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН УУЛ
УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ТӨСӨЛ – НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ (P145439)-ИЙН ТАЛААР**

**УДИРДЛАГААС ХЯНАЛТЫН ХОРООНД ИРҮҮЛСЭН
ШИНЭЧЛЭГДСЭН МЭДЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ**

Огноо: 2016 оны 5 дугаар сарын 17

1. Энэ тэмдэглэлд Хяналтын хорооноос төслүүдийн талаар 2015 оны 7 дугаар сарын 2-ний өдөр гаргасан 97875-MN дугаартай тайланд хөндөж тавьсан асуудлуудыг шийдвэрлэх тал дээр гарсан ахицыг дүгнэсэн болно.

2. **Үндэслэл:** Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн (УУДБХОДТ) зорилго нь санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхийг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг бэлтгэж, хэрэгжүүлэх дотоодын чадавхийг нэмэгдүүлэхэд оршино. Төслийн цар хүрээ нь улс үндэстнийг бүхэлд нь хамрах бөгөөд судалгааны бэлтгэл ажил, тэр дундаа техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийх, байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах, чадавхи бүрдүүлэх зэрэг зөвхөн техникийн талын туслалцааг санхүүжүүлнэ. Төслийн хүрээнд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй. Хянан шалгалт хийлгэх хүсэлтэд дурдсан усан цахилгаан станцын хоёр төсөл буюу тэргүүний ач холбогдол бүхий дэд төслүүдийн хувьд техник эдийн засгийн үндэслэлийн (ТЭЗҮ) судалгаа болон байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОННБҮ) ажлыг УУДБХОДТ-ийн хүрээнд санхүүжүүлэх боломжтой гэж тодорхойлсон байдаг. Хоёр дэд төсөл болох Шүрэнгийн усан цахилгаан станц (ШУЦС) болон Орхон-Говь ус дамжуулах (ОГ) төсөл нь Орос, Монгол хоёр улсын нутаг дэвсгэрийг хоёуланг нь хамарсан газар буюу Сэлэнгэ мөрний сав газар хэрэгжинэ. Үүнээс гадна ШУЦСТ болон ОГ нь хоёулаа дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн Байгаль нуур болон Рамсарын конвенцид орсон Сэлэнгэ мөрний адаг хэсэг дэх намгархаг газруудад нөлөө үзүүлэх болно. Тиймээс Банкны үйл ажиллагааны бодлогын шаардлагуудыг хангах үүднээс урьдчилсан судалгаа, магадлан шинжилгээ хийж байж л Орос болон Монгол улсад зөвлөлдөх уулзалт зохион байгуулах шаардлагатай байгаа юм.

3. Эдгээр нарийн төвөгтэй дэд төслийг тойрсон эмзэглэл, санаа зовнилт, мөн оролцоо, ил тод байдлыг сайжруулах шаардлага нь 2015 оны 2 дугаар сард Хяналтын хороонд хүсэлт гаргахад нь зарим ТББ, нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн төлөөлөлд түлхэц болж өгсөн юм. Хяналтын хороо уг хүсэлтийг бүртгэж авах боломжийг судалж үзсэн хэдий ч Банкны зүгээс явуулсан, эс явуулсан үйл ажиллагааг шалгах шаардлага байгаа эсэх талаар шийдвэр гаргахад нэг жилээр хойшлуулсан бөгөөд энэ хугацаа нь 2016 оны 6 дугаар сарын сүүлээр дуусах юм.

4. Энэ тайланд Хороо дараах гол санаануудыг онцлон тэмдэглэжээ. Үүнд: (i) Монгол болон Орос улсад төслийн үйл ажиллагааны нөлөөлөд өртсөн нутгийн иргэдтэй зохих ёсоор

зөвлөлдөх шаардлага; (ii) төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх газрууд, тэр дундаа Сэлэнгэ мөрөн (урсгал өөд болон дагуух газрууд), Рамсарын конвенцид орсон намгархаг газрууд, Байгаль нуур зэрэг газрын онцлог шинж чанарт анхаарал хандуулж, судалгааг зохих ёсоор явуулахад хангалттай цаг хугацаа, нөөц бололцоогоор хангах үүднээс Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ (БНБОУ) болон БОННБҮ-ний ажлын даалгаврыг дахин хянаж үзэх шаардлага, (iii) ирэх 20 жилийн хугацаанд Сэлэнгэ мөрний сав газарт барьж байгуулахаар төлөвлөгдсөн эсвэл төлөвлөгдөж болзошгүй бүх усан цахилгаан станцын төслийг хамарсан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (ХНҮ) хийх заалтуудыг ажлын даалгаварт тусгах шаардлага зэрэг багтана. Эдгээр зөвлөмж нь Хяналтын хорооны ажлын хэсгийн хийсэн томилолтын өмнөхөн 2015 оны 4 дүгээр сард томилолтоор ажилласан ЮНЕСКО-ийн үнэлгээний багийн дүгнэлттэй нийцэж байгаа юм.

5. **Ахиц:** Хяналтын хорооны тайлан 2015 оны 7 дугаар сард гарснаас хойш зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, ажлын даалгаврыг дахин хянаж үзэх, шинэчлэх тал дээр нэлээд их ахиц гарсан байна. Эдгээр ахицын талаар доор хэлэлцэнэ.

6. **Зөвлөлдөх уулзалт:** 2015, 2016 онд төсөл хэрэгжүүлэх агентлагууд нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд болон бусад оролцогч талыг оролцуулсан 8 зөвлөлдөх уулзалт зохион байгуулжээ. Үүнээс 5 нь ШУЦСТ-ийн талаарх ойлголт, ажлын даалгаврыг хэлэлцэх уулзалт, үлдсэн 3 нь ОГТ-ийн талаарх уулзалт байв. Уулзалт бүрийн үеэр оролцогчдын санал бодлыг сонсож, хариултын матриц хүснэгт боловсруулж, улмаар хүлээн авсан санал хүсэлт, зөвлөмжийн дагуу ажлын даалгаврыг хянан шинэчилсэн.

- *Шүрэнгийн талаарх зөвлөлдөх уулзалтууд:* 2015 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр (1) Улаанбаатар хотод 74 оролцогч талыг оролцуулсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулсны хажуугаар (2) Булган аймгийн Сэлэнгэ сумын Цүүц багт 5 дугаар сарын 23-ны өдөр 7 оролцогч талтай, мөн (3) Булган аймгийн Сэлэнгэ сумын Атар багт 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдөр 30 оролцогч талтай зөвлөлдөх уулзалт зохион байгууллаа. Эдгээр арга хэмжээнд оролцсон хүмүүс ихэвчлэн төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутагт оршин суудаг малчид байсан. Улмаар Орос, Монголын засгийн газар хоорондын харилцаанд нэг хэсэг ямар ч ахиц гаралгүй, идэвхгүй байсны дараагаар орон нутгийн ард иргэдийг дахин татан оролцуулах үүднээс 2016 оны 4 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд (4) Сэлэнгэ сум, (5) Атар багт нутгийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулав. Эдгээр уулзалтын талаарх тайлангууд удахгүй бэлэн болно.
- *Орхоны талаарх зөвлөлдөх уулзалтууд:* 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр (1) Улаанбаатар хотод 49 оролцогч талыг хамруулсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулсны хажуугаар Орхоны төслийн талаарх нутгийн зөвлөлдөх уулзалтыг (2) Хангал сумын Хишигөндөр, (3) Хялганат тосгонд 2016 оны 4 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгууллаа. Эдгээр уулзалтын талаарх тайлангууд удахгүй бэлэн болно. Үүн дээр нэмж хэлэхэд урьдчилсан ТЭЗҮ судалгааны үе шатыг дахин эргэж харахад төслийн ойлголтын талаарх нутгийн зөвлөлдөх уулзалтуудыг Төв, Дундговь, Өмнөговь, Булган, Архангай зэрэг аймгуудад 2013 оны 11 дүгээр сарын 11-ээс 17-ны хооронд нийтдээ нутгийн 40 оролцогчийг хамруулан зохион байгуулжээ.
- *Орос улсад зохион байгуулагдсан зөвлөлдөх ба техникийн уулзалтууд:* Оросын оролцогч талууд Орос улсад гурван том уулзалт зохион байгуулсан байна. Эдгээр нь:

- Буриад улсын Кабански дүүргээс 2016 оны 2 дугаар сарын 28-нд зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан. Ойролцоогоор 43 оролцогч тал дээрх уулзалтад оролцжээ. Зөвлөлдөх уулзалтаас гарсан үр дүнгийн (уулзалтын протокол, санал хүсэлт, урьдчилсан байдлаар боловсруулсан ажлын даалгаврын талаарх зөвлөмж) талаар Банк болон УУДБХОДТ-ийн удирдлагын багт танилцуулсан.
- ОХУ-ын Байгалийн нөөц баялаг, байгаль орчны яам техникийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэхүү уулзалт 2016 оны 4 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд Москва хотноо явагдсан. Оролцогчдын дунд байгаль орчны эрдэм шинжилгээний ажилтнууд, иргэний нийгмийн байгууллагууд (ИНБууд), Буриад улсын төрийн албан тушаалтнууд болон эрдэмтэд байв. Банк болон УУДБХОДТ-ийн удирдлагын багын дарга уг уулзалтад оролцсон. Уулзалтын үеэр төслийн удирдлагын багийн дарга Монгол улсаас 5, 6 дугаар саруудад Орос улсад зохион байгуулахаар төлөвлөж байгаа зөвлөлдөх уулзалтуудын төлөвлөгөөг танилцуулав. Мөн Оросуудаас уг саналыг судалж үзээд, төслийн удирдлагын багт 2016 оны 4 дүгээр сарын сүүлээр хариу өгөхийг хүссэн. Гэвч тэд 5, 6 сар нь хэтэрхий ойрхон байгаа тул хуваарийг хойшлуулж, уян хатан байлгах нь бодит нөхцөл байдалд илүү дөхөм байна гэж үзсэн. Монголчууд харин энэ нь зөвлөлдөх үйл явцыг хойш нь татаж болзошгүй гэж харж байна.
- Бүс нутгийн ИНБууд 2015 оны 11 дүгээр сард Иркутск хотноо Сибирийн гол мөрнүүд сэдэвт бүс нутгийн хурал зохион байгуулсан. Банкны удирдлага уг хуралд оролцож, Банкны хамгааллын бодлогуудаа танилцууллаа. БОННБҮ-ний ажлын даалгаврын эцсийн хувилбарыг боловсруулах явцад тусгуулах үүднээс хурлаас гарсан үр дүн, зөвлөмжүүдийг Банкинд хүргүүлж, төслийн удирдлагын багт танилцуулсан.

7. Монголын тал зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, санал хүсэлт, хөндөж тавьсан асуудалд хариу өгөх талын чадавхи сайн байгаагаа дараах зүйлээр харуулсныг дурдах нь чухал билээ. Үүнд:

- Зөвлөлдөх уулзалтын үеэр, мөн хөндлөнгөөс хүлээн авсан санал хүсэлт бүрт хариу өгөх зорилгоор хариултын нарийвчилсан матриц хүснэгт боловсруулсан. Төслийн удирдлагын баг зөвлөлдөх уулзалтын үеэр хүлээн авч, бүртгэсэн санал хүсэлт бүрийг анхаарч үзэх, үүнийгээ ажлын даалгаварт тусгах эсвэл өөр арга зам санал болгох байдлаар буюу бүтээлч хандлагаар илэрхийлж байгааг хөхүүлэн дэмжиж байна.
- Зөвлөлдөх уулзалтын дэлгэрэнгүй тайлангийн нэгтгэл.
- Зөвлөлдөх, мэдээллийг олон нийтэд ил болгох нарийвчилсан удирдамж боловсруулж, хэрэгжүүлсэн. Үүнд зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, УУДБХОДТ-ийн холбогдох судалгааны мэдээллийг нийтэд ил болгох явдлыг Банкны хамгааллын бодлогод заасан шаардлагад нийцүүлэхэд чиглэгдсэн практик алхамууд багтаж байна.
- УУДБХОДТ-ийн гомдол барагдуулах механизм боловсруулж, олон нийтэд танилцуулсан. Ингэхдээ уг механизмын зорилго, боломжит асуудлууд, санал хүсэлт, шийдвэр хүлээн авах хугацаа, дараа дараагийн шатны байгууллагад хандах хувилбарууд, мэдээлэхэд тавигдах

шаардлага зэргийг тайлбарласан байна. Саяхан 2016 оны 4 дүгээр сард Шүрэнгийн болон Орхоны төслийн талаар хийсэн зөвлөлдөх уулзалтуудын үеэр энэхүү механизмыг олон нийтэд танилцуулсан бөгөөд УУДБХОДТ-ийн талаар цаашид зохион байгуулагдах бүх зөвлөлдөх уулзалтын үеэр танилцуулж байхаар төлөвлөжээ.

- Орхоны болон Шүрэнгийн төслийн судалгааны ажилд хяналт тавих үүднээс Орос, Монгол болон гуравдагч улсын байгаль орчин, нийгэм, усны эрчим хүчний мэргэжилтнүүдээс бүрдсэн Олон улсын зөвлөх хороонд зориулж ажлын даалгаврын урьдчилсан хувилбарыг бэлтгэж гаргалаа.
- Төслийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс төслийн вэбсайтыг сайжруулжээ. Вэбсайтын холбоос: <http://client.embersoft.mn/mn/showcase> (Хэрэглэгчийн нэр: admin@minis.mn Нууц үг: admin2016. Хувилбар 1.2-ийн хажууд байрлах УЛААН товч дээр дар.)

8. **ШУЦС болон ОГ төслийн БОННБҮ-ний ажлын даалгаврыг дахин хянаж, шинэчлэх:** ИНБууд болон ЮНЕСКО-ийн ажлын хэсгийн гаргасан тайланд хөндөгдсөн асуудал, санал хүсэлт, зөвлөмжид үндэслэн БОННБҮ-ний ажлын даалгаврыг шинэчилж, хянасан. БНБОУ, БОННБҮ, ХНУ-ний үе шатуудыг улам боловсронгуй болгож, судалгааны үргэлжлэх хугацаа, төсвийг нэмэгдүүлж, хамрах цар хүрээг тэлж Сэлэнгэ мөрний сав газар, Байгаль нуур, адаг хэсгийн намгархаг газруудыг багтаахаар болсон. Шүрэнгийн болон Орхоны төслүүдийн БОННБҮ-ний ажлын даалгаврын хувьд хил дамнасан зөвлөлдөх уулзалтын нэмэлт үйл явцыг зохих ёсоор дуусгасны дараагаар л эцэслэх болно.

9. Монгол талын удирдлага дор явагдсан хянаж, шинэчлэх үйл явцад Банк Монголын талын хэрэгжүүлэгч агентлагуудад техникийн туслалцаа үзүүлсэн. Эдгээрт дараах үйл ажиллагаа багтана:

- Байгаль орчны хамгааллын зөвлөхүүд болон ажилтнууд 2015 оны 6 дугаар сард техникийн тойм судалгаа хийх томилолтоор ажиллаж, УУДБХОДТ-д нэгдсэн. Уг ажлын хэсэг Орос, Монгол улс дахь төслийн үйл ажиллагаанд өртсөн нутгуудаар айлчилж, Улаан Үд, Иркутск хот болон Байгаль нуурын орчимд ОХУ-ын Шинжлэх ухааны академийн төлөөлөл, Сэлэнгэ мөрний судалгааны ажлыг хийж буй НҮБ-ын Төслийн үйлчилгээний албаны ажилтнуудтай уулзав. Ажлын хэсгийнхэн орос хэл дээр орчуулж, улмаар олон нийтэд танилцуулж, санал сэтгэгдэл цуглуулах үүднээс төслийн вэбсайт дээр байршуулсан ажлын даалгавруудын шинэчлэгдсэн хувилбарыг нийтэд мэдээлэхэд тусалсан.
- Зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, техникийн хэлэлцүүлэг явуулж, сонирхлын бүлгээс санал хүсэлт хүлээж авсны дараагаар ажлын даалгаврын урьдчилсан хувилбарыг дахин хянаж, шинэчиллээ. 2015 оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо явагдсан Монгол-Оросын хил дамнасан хорооны уулзалтын үеэр орос хэл дээр орчуулагдсан ажлын даалгаврыг ОХУ-ын Байгалийн нөөц баялаг, байгаль орчны яамны төлөөлөгчдэд бас танилцууллаа. Гэвч Оросын төлөөлөгчид ажлын даалгаврыг тус яаманд албан ёсоор ирүүлэхийг хүссэн юм. Энэ нь тодорхой хэмжээнд удаашрал үзүүлсэн. Банкны удирдлага ШУЦС, ОГТ-ийн шинэчлэгдэж, орчуулагдсан ажлын даалгаврыг 2016 оны 2 дугаар сард ОХУ-ын яаманд албан ёсоор хүргүүлсэн.

10. **Одоогийн төлөв:** БОННБҮ-ний зөвлөх сонгох үйл явцыг урагш хөдөлгөхийн тулд Монголын тал ОХУ дахь нөлөөлөлд өртөх газар нутгуудад зөвлөлдөх уулзалт зохион байгуулах шаардлагатай хэвээр байгаа юм. Банкны удирдлага 2016 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Сангийн сайд, Эрчим хүчний сайд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд нартай дээд түвшний уулзалт хийж, Банкны үйл ажиллагааны бодлого, тэр дундаа ҮАБ 4.01-д нийцүүлэх нь нэн чухал болохыг онцолсон билээ. Монгол улсад хэд хэдэн зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан хэдий ч БОННБҮ-ний ажлын даалгаврыг эцэслэн батлах, улмаар зөвлөх сонгох үйл явцын урьдач нөхцөл бол нөлөөлөлд өртөх бүх нутгийн иргэд, тэр дундаа Орос улсад оршин суудаг иргэдтэй зөвлөлдөх уулзалт хийх явдал юм. БОННБҮ болон ТЭЗҮ судалгаа нь өөр хоорондоо холбоотой тул Банк шалгуурт тэнцсэн ТЭЗҮ зөвлөхүүдийн жагсаалтыг 2015 онд хэдийнээ баталж гаргасан.

11. УУДБХОДТ-ийн удирдлагын багийн дарга нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд болон орон нутгийн ИНБуудтай зөвлөлдөх уулзалтыг Орос улсад зохион байгуулах саналыг ОХУ-ын Байгалийн нөөц баялаг, байгаль орчны яамнаас 2016 оны 4 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Москва хотоо зохион байгуулсан мэргэжилтнүүдийн уулзалтын үеэр танилцуулсан билээ. Мөн түүнчлэн уг саналыг оролцогч талуудад тарааж, 4 дүгээр сарын сүүлээр санал хүсэлтээ ирүүлэхийг хүссэн юм. Монгол улсын Засгийн газраас зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах хүсэлтээ албан ёсоор ирүүлж, улмаар ОХУ-ын Гадаад хэргийн яам тухайн хүсэлтийг авч үзсэний дараагаар зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулахад нэлээд хэдэн сарын хугацаа шаардагдах нь дамжиггүй.

12. Дээр дурдсанаас харахад зөвлөлдөх уулзалтуудыг Банкны үйл ажиллагааны бодлогын дагуу зохион байгуулж, явуулах тал дээр ихээхэн ахиц гарсан байна. Цаашилбал бүх оролцогч талыг татан оролцуулах, Орос улсад зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах хэрэгцээ, шаардлагыг хүлээн зөвшөөрөх тал дээр томоохон хүчин чармайлт гаргажээ. Нэмж дурдахад ажлын даалгаврыг дахин хянаж, шинэчилсэн бөгөөд хүлээн авсан санал хүсэлтүүдийг тусгахыг зорьсон байна. ШУЦС болон ОГТ-ийн урьдчилсан судалгааны ажилд ийнхүү анхаарал хандуулж байгаа нь хэрэгжүүлэгч агентлагуудын чадавх, гүйцэтгэлийг ихээхэн сайжруулсан нэмэлт давуу талтай байлаа.

13. Монгол улс Оросын хамтрагч талуудыг татан оролцуулах, хил дамнасан хорооны албан ёсны тогтмол уулзалтуудаар дамжуулан дээд түвшинд зөвлөлдөх тал дээр хичээл зүтгэл гарган, сайн ажиллалаа. Хүлээн авсан санал хүсэлтүүдэд түргэн шуурхай хариу өгч, ажлын даалгаврыг шинэчилж, төслийн вэбсайт дээр англи, монгол, орос хэлээр байршуулах замаар олон нийтэд танилцуулжээ. Орос улсад зөвлөлдөх уулзалт зохион байгуулагдсанаар ажлын даалгаврыг эцэслэн батлах хугацаа ойртох болно.

14. **Цаашид:** Эрх баригчдын хооронд хийгдэх албан харилцаанд их хугацаа ордог тул Орос улсад зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж эхлэх хүртэл нэлээд хугацаа өнгөрөх төлөвтэй байна. Гэхдээ УУДБХОДТ-ийн удирдлагын баг Банкнаас томилогдсон ажлын хэсгийн тусламжтайгаар 5 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Монгол улсад зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн Орос, Монгол улсын байгаль орчны яамдын хурлаар Буриад улсад зөвлөлдөх уулзалт явуулах тухай албан ёсны гэрээ байгуулах тал дээр ахиц гаргахаар зорин ажиллаж байна. Мөн түүнчлэн Буриад улсад байрладаг ИНБуудын төлөөлөгчид, тэр

дундаа Хил хязгааргүй гол мөрөн байгууллагатай уулзаж, тэдгээрийг зөвлөлдөх уулзалтад хамруулах талаар хэлэлцжээ. 4 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд Москва хотноо болсон мэргэжилтнүүдийн уулзалт дээр тараасан зөвлөлдөх уулзалтын саналтай холбоотой санал хүсэлтийг төслийн удирдлагын багт бас өгсөн бөгөөд уг санал хүсэлтийг төлөвлөгөөндөө тусгах тал дээр идэвхтэй ажиллаж байна.

15. Банкны удирдлага 2016 оны 5 дугаар сарын 2-нд ОХУ-ын Байгалийн нөөц баялаг, байгаль орчны яамнаас (БНББОЯ) зохион байгуулсан техникийн хэлэлцүүлэг-уулзалтын хүрээнд 4 дүгээр сарын 11, 12-нд Москва хотноо явагдсан хэлэлцүүлэг, гарсан ахицын талаар Оросыг хариуцсан гүйцэтгэх захиралд мэдээлсэн. Энэхүү уулзалт нь Монгол, Орос улс хоорондын албан харилцааг түргэвчлэх тал дээр зөвлөгөө, дэмжлэг авахад чиглэгдэж байсан юм.

16. Албан ёсны гэрээ байгуулсны дараагаар УУДБХОДТ-ийн удирдлагын баг Оросын албан ёсны хүлээн авагч талтай холбоо тогтоож, зөвлөлдөх уулзалтуудын талаар нийтэд зарлах, баримт бичиг боловсруулж тараах, Буриад улсад зөвлөлдөх уулзалт зохион байгуулах төлөвлөгөөний удирдамжаар хангах болно. Оросын ИНБуудтай хийсэн хэлэлцүүлгийн явцад ОХУ-ын нутаг дэвсгэрт орших Сэлэнгэ мөрний сав газар дахь дүүргүүдэд амьдардаг, төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэдийг хамруулан зохион байгуулах боломжтой зөвлөлдөх уулзалтын тоо, газрын байршлыг тодорхойлсон билээ. Эдгээр байршлыг Оросын хүлээн авагч тал дэмжиж батлах ёстой юм.

17. Дараа нь УУДБХОДТ-ийн удирдлагын баг бэлтгэл ажил хангах ажлын хэсгийг томилно. Уг ажлын хэсэг Оросын хүлээн авагч тал болон Банкны ажлын хэсгийн дэмжлэг, мөн ИНБууд болон Буриад улсын орон нутгийн засаг захиргааны оролцоотойгоор зөвлөлдөх уулзалт зохион байгуулах чиглэлээр ОХУ-д томилолтоор ажиллана. Энэхүү үйл явц Сибирийн өвөл эхлэхээс өмнө дууссан байна гэж найдаж байна.

“Энэхүү баримт бичгийг сонирхсон талуудад зориулж англи эхээс нь орчуулав. Эх баримт болон орчуулгын хооронд зөрүү гарвал англи хэл дээрх эхийг баримтална.”